БАТЛАВ:

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР БӨГӨӨД
ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

Г.БАТЗОРИГ

УЛААНБААТАР ХОТЫН ҮЕРИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ, БОХИР УСНЫ ШУГАМ ХООЛОЙГ ШУУДУУ УХАЛГҮЙГЭЭР ДОТОРЛОХ, ШИНЭЧЛЭХ ТЕХНОЛОГИЙГ НЭВТРҮҮЛЭХ ТӨСЛИЙН ХҮРЭЭНД

БАГЦ 2. УЛААНБААТАР ХОТЫН БОХИР УСНЫ ШУГАМ ХООЛОЙГ ШУУДУУ УХАЛГҮЙГЭЭР ДОТОРЛОХ АЖЛЫН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ БАРИМТ БИЧИГ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

Агуулга

1. Төслийн суурь мэдээлэл 4
1.1. Бүрэлдэхүүн хэсэг 2: Бохир усны шугам хоолойг шуудуу ухалгүйгээр доторлох, шинэчлэх технологи 6
1.2. Санхүүжилтийн хэлбэр 8
1.3. Төсөлд тулгарч болзошгүй хүндрэлүүд 8
2. БОННҮ-ний зорилго ба хамрах хүрээ 9
2.1. БОННҮ-ний зорилго 9
2.2. БОННҮ-ний хамрах хүрээ 10
3. Бодлого, хууль эрхзүйн орчин 13
3.1. Дэлхийн банкны байгаль орчин, нийгмийн стандартууд (БОНС)14
3.2. Монгол Улсын хууль тогтоомж 16
4. Гүйцэтгэх ажлын тойм 17
4.1. Төслийн бүрэлдэхүүн хэсгийн шинжилгээ ба хураангуйг бэлтгэх17
4.2. Анхан шатны үнэлгээ ба урьдчилсан дүн шинжилгээ 17
4.3. Байгаль орчны суурь мэдээлэл цуглуулах 18
4.4. Нийгмийн суурь мэдээлэл цуглуулах 20
4.5. Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ 31
4.6. Нөлөөллийг бууруулах арга хэмжээ ба менежментийн төлөвлөгөө 24
4.7. Оролцогч талуудын оролцоо ба мэдээллийг олон нийтэд түгээх 25
4.8. Гомдол барагдуулах механизм (ГБМ) 26
4.9. Байгалийн болон чухал амьдрах орчныг хамгаалахтай холбоотой шаардлага 26
5. Зөвлөхийн хүлээлгэн өгөх баримт бичгийн жагсаалт 26
5.1. Хүлээлгэн өгөх баримт бичиг болон форматын шаардлага 28
6. Ажлын даалгаврын үргэлжлэх хугацаа ба хуваарь 28
7. Үүрэг, хариуцлага 28
Захиалагчийн үүрэг хариуцлага: 28
7.1. ТЭЗҮ боловсруулах багтай хамтран ажиллах 29
7.2. Ажлын даалгаврын уян хатан байдал 29
8. БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН, МЭРГЭШЛИЙН ШААРДЛАГА 30
9. Төлбөрийн хуваарь 33
ХАВСРАЛТ 1: БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН НӨЛӨӨЛӨЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ЖИШИГ ЗАГВАР 34
ХАВСРАЛТ 2: БОНМТ-ний жишиг загвар 36
ХАВСРАЛТ 3: ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ОРОЛЦООГ ХАНГАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИШИГ ЗАГВАР 37
ХАВСРАЛТ 4: НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭЛТИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ЖИШИГ ЗАГВАР 38
ХАВСРАЛТ 5: ХӨДӨЛМӨРИЙН УДИРДЛАГЫН ЖУРМЫН ЖИШИГ ЗАГВАР 41

ХАВСРАЛТ 6: БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮЛГЭРЧИЛСЭН ДҮРМИЙН ЖИШИГ ЗАГВАР 43
ХАВСРАЛТ 7: ТҮР ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИШИГ ЗАГВАР 43

Зургийн жагсаалт

Зураг 1 Улаанбаатар хотын ус хангамжийн шугам сүлжээ
Зураг 2 Улаанбаатар хотын ариутгах татуургын шугам сүлжээ .....
Зураг 3 Бүрэлдэхүүн хэсэг 2-ын дагуу шинэчлэх, өргөтгөх шугам сүлжээний мэдээлэл 8

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1 Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлэхээр төлөвлөж буй үйл ажиллагааны цар хүрээ..... ..

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

БОННҮ	Байгаль орчин нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ
БОНҮАҮД	Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны үлгэрчилсэн дүрэм
БОНЗТ	Байгаль орчин, нийгмийн зорилтын төлөвлөгөө
БОННҮ	Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ
БОНМТ	Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө
БОНС	Байгаль орчин, нийгмийн стандартууд
БОУАӨЯ	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам
БОЭМААУ	Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны удирдамж
ГБМ	Гомдол барагдуулах механизм
ДБ	Дэлхийн Банк
НШТ	Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө
НШБББ	Нүүлгэн шилжүүлэлтийн бодлогын баримт бичиг
НЗДТГ	Нийслэлийн засаг даргын тамгын газар
ОТОХТ	Оролцогч талуудын оролцоог хангах төлөвлөгөө
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ТЗХМТ	Түр замын хөдөлгөөний менежментийн төлөвлөгөө
УБЗАА	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба
ХАБЭА	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
ХУЖ	Хөдөлмөрийн удирдлагын журам

1. Төслийн суурь мэдээлэл

Сүүлийн жилүүдэд өсөн нэмэгдэж буй үерийн эрсдэл, эрчимтэй явагдаж буй хотын тэлэлт ба хотжилт, хуучирсан дэд бүтэц зэрэг нь Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод тулгарч буй томоохон сорилт болоод байна. Улаанбаатар хот Туул голын сав газарт далайн түвшнээс 1350 метрийн өндөрт, уулархаг газраар хүрээлэгдэн байрладаг. Нийслэлийн газар нутаг н 4,704 км² талбайг хамарч, есөн дүүрэгт хуваагддаг бөгөөд ойролцоогоор 1.64 сая хүн амьдардаг нь Монгол улсын нийт хүн амын тал орчим хувьтай тэнцдэг. Сүүлийн жилүүдэд хотын хүн ам, газар нутгийн хурдацтай тэлж буй нь үерийн гамшгийн менежмент, бохир усны дэд бүтцэд ачаалал үүсгэж байна.

Тухайлбал, 2023 оны Сэлбэ голын үер Улаанбаатар хотын нийгэм, эдийн засаг, дэд бүтцэд ихээхэн хохирол учруулсан. Сэлбэ голын үерт ихээхэн хэмжээний орон сууц, барилга байгууламж, аж ахуйн нэгж болон инженерийн шугам сүлжээ өртөж, нийт 11,956 өрх, 34,473 иргэн үерийн хохирол амссан. Цаашлаад, 74,023 хэрэглэгчийн цахилгаан тасарч, үерийн улмаас дөрвөн хүн амиа алдсан харамсалтай хэрэг гарсан. Энэхүү гамшиг нь Улаанбаатар хотод үерийн хамгаалалтын арга хэмжээг сайжруулах, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй хот төлөвлөлтийг яаралтай хийх хэрэгцээ шаардлага байгааг харуулсан.

Уур амьсгалын өөрчлөлт ба байгаль орчны нөхцөл байдал

Монгол орны хувьд уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэн аадар бороо, үер зэрэг цаг агаарын эрс тэс үзэгдлийн давтамж, эрчим тасралтгүй нэмэгдэж байгаа бөгөөд Үндэсний статистикийн хорооны мэдээгээр Монгол Улсад 2009-2011 онд их хэмжээний аадар бороо, үерийн тоо 10-14 удаа байсан бол сүүлийн хоёр жилд энэ тоо огцом нэмэгдэж 107-309 болсон байна. Түүнчлэн 1%-ийн хангамшилтай буюу 100 жилд нэг удаа тохиох үерийн давтамж өсөх магадлал нь үерийн эрсдэлийг бууруулах дасан зохицох стратегийн чухал хэрэгцээ шаардлага байгааг харуулсан. Газар ашиглалтын өөрчлөлт, орчны бохирдлын улмаас Улиастай, Сэлбэ, Туул голын дагуух эрэг орчмын бүсүүдийн байгаль экологийн төлөв байдал алдагдаж, доройтолд орсон нь биологийн олон янз байдал, экосистемийн үйлчилгээг хадгалах ажлыг улам хүндрүүлж байна.

Физик газарзүй

Улаанбаатар хот нь газарзүйн хувьд хойд өргөргийн 48°23'32”, өмнөд уртрагийн 48°23'32” солбилцолд Хэнтийн нурууны үргэлжлэл болох Богд хан уулын бэлд Туул голын ай сав газарт далайн түвшнээс дээш 1350 метрийн өндөрт оршдог. Улаанбаатар хот нь нийт 500,000 га нутаг дэвсгэртэй ба усны сан бүхий газар нийт нутаг дэвсгэрийн 0.9 хувийг эзэлдэг.
Нийслэлийн газрын нэгдмэл сангийн үндсэн ангилал дараах байдалтай байна.

- Хөдөө аж ахуйн газар: 265,980.1 га (57%)
- Хот тосгон бусад суурин газар: 41,084.5 га (9%)
- Зам талбайн, шугам сүлжээний газар: 5679.0 га (1%)
- Ойн сан бүхий газар: 76,966.8 га (16%)
- Усан сан бүхий газар: 4,078.1 га (1%)
- Улсын тусгай хэрэгцээний газар: 76655.4 га (16%)

Улаанбаатар хотын нийт нутаг дэвсгэрийн 7.4 хувийг хот суурины газар эзэлдэг бөгөөд орон сууц, гэр хороолол нь ойролцоогоор 7735.9 га талбайг эзэлдэг.

Уур амьсгал

Улаанбаатар нь эх газрын эрс тэс уур амьсгалтай, дэлхийн хамгийн хүйтэн нийслэл хот гэдгээрээ онцлог юм. Хамгийн хүйтэн агаарын дундаж температур 1-р сард -26°C хүрдэг бол хамгийн дулаан агаарын дундаж температур 7-р сард +17°C байдаг. Агаарын үнэмлэхүй их температур 7-р сард +39°C, хамгийн бага температур 1-р сард -40°C хүрнэ.

Агаарын жилийн дундаж харьцангуй чийгшил 61%, хур тунадасны хувьд 350-450 мм орчимд хэлбэлздэг ба жилийн нийт хур тунадасны 75-80% нь зуны саруудад голчлон унадаг.
Хур тунадасны зүй тогтлын хувьд:

- Өдөр тутмын хур тунадасны хэмжээ 120-130 мм (100 жилд нэг удаа), 58-98 мм (20 жилд нэг удаа).
- Хур борооны хамгийн их эрчим нь минутад 1.5 мм ба хуртай жил бороо орсноос голын усны түвшин эрс нэмэгдэж, хаврын улиралд шар усны үер тохиолдож болзошгүй байдаг.

Салхи зонхилон хойд, баруун хойд зүгээс салхилдаг ба салхины жилийн дундаж хурд 2.4 м/сек. Сүүлийн 60 жилийн хугацаанд хотжилтын нөлөөгөөр Улаанбаатар хотын агаарын дундаж температур 2°C нэмэгдсэн нь Монгол орны дундаж болох 1,8°C-аас давсан үзүүлэлттэй байна.

Геологийн нөхцөл

Геологийн тогтцын хувьд Улаанбаатар хот нь Монгол орны геологи тектоникийн ангиллын Хэнтийн геосинклиналь хотгорт харьяалагдана. Районы геологийн тогтцод доод карбон, доод цэрд, неоген, дөрөвдөгчийн хурдас чулуулаг, доод мезозойн интрузи бүрдэл оролцоно. Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд геологийн тогтцын хувьд доод-дунд девоны настай бялхмал-тунамал чулуулгийн зузаалаг, түүнчлэн делюви-пролюви болон аллювийн гарал үүсэлтэй дээд плейстоцен-орчин үеийн сэвсгэр хурдас зонхилон тархсан байна.

Хөрсөн бүрхэвч

Улаанбаатар хотын нутаг дэвсгэр нь ойт-хээрийн бүсийн урд хэсэгт голын хөндийд байрлах учраас хээрийн хөрс, голын татмын хөрс, уулын ойн хөрс зонхилдог. Хотын төв хэсгийн хөрс нь маш хүчтэй элэгдэл талхагдалд орж, үржил шимт чанараа бүрэн алдсан ялангуяа гэр хороололд хамгийн их байдаг. Ихэнх тохиолдолд хөрсний дээд хэсгийн үржил шимт ялзмагт давхарга нь бүрмөсөн алга болж, хөрс үүсгэгч чулуулаг хайрган хурдас гадарга дээр ил гарсан байдаг.
Нийслэлийн нутаг дэвсгэр дээрх эвдэрсэн газрын тооллого, судалгааны дүнгээс харахад сүүлийн жилүүдэд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын буруутай үйл ажиллагаанаас болж Улаанбаатар хотын хөрсний 13 % нь ямар нэг хэмжээгээр эвдэрсэн бол нийт эвдэгдсэн талбайн 70 % нь хүчтэй доройтож цөлжсөн байдалтай байна.

Ургамлан нөмрөг

Уулын нуга, ой мод, хээрийн бүсийн уулзварт оршдог Улаанбаатар хотын ургамалжилт ойролцоогоор 281454.2 га талбайг эзэлдэг. Үүнд:

- Уулын нуга: 0.7%
- Ой мод: 25.2%
- Хээр : 24.7%
- Голын хөндийн нуга: 7.8%
- Хужирлаг нуга: 3.4%

Улаанбаатар хот нь ургамлын зүйлийн хувьд баялаг, содон хэв шинжийг агуулсан хэдий ч хот орчмын өвслөг ургамалтай талбайн 51.7% нь талхагдалд орсны дотор хүчтэй талхлагдсан газар 43,8 мянган га талбай, дунд зэрэг талхлагдсан 14,1 га талбай байна.

Амьтны аймаг

Хотжилт нь Улаанбаатар хотын экосистемд ихээхэн нөлөөлсөн бөгөөд үүний үр дүнд синантроп төрөл зүйлүүд олширсон. 2016-2021 оны хооронд тус хотын хөхтөн амьтдын төрөл зүйл 53-аас 58 зүйл болж нэмэгдсэн нь Монгол орны нийт хөхтөн амьтдын зүйлийн бүрдлийн 40 гаруй хувийг эзэлж байна. Үүнд:

- Шавж идэштэн: 5 зүйл

- Гар далавчтан: 5 зүйл
- Туулай хэлбэртэн: 5 зүйл
- Мэрэгч амьтад: 22 зүйл
- Махчин идэштэн: 14 зүйл
- Туруутан: 7 зүйл

Нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал

Нийгмийн эмзэг байдал нь Улаанбаатар хотын үерийн эрсдэлийг нэмэгдүүлэх гол хүчин зүйлүүдийн нэг болж байна. Орон нутгаас шилжин ирэгсэд, зөвшөөрөлгүй айлууд ихэвчлэн үерийн эрсдэлтэй бүсэд байрладаг бөгөөд хотын хамгийн эмзэг, өртөмтгий бүлгийн хүн ам тухайн бүсэд суурьшсан байдаг. Эдгээр бүлгийн хүн ам дэд бүтцэд холбогдох боломж хязгаарлагдмал, цаашлаад газар эзэмших, амьжиргааны эх үүсвэртэй болоход хүндрэлтэй байдаг. Үерийн гамшгийн нөлөө, хохирол нь хүн амын эдгээр бүлгүүдэд харьцангуй хүндээр тусдаг ба гэр бүлийн орлого, амьжиргаа, эрүүл мэндийн эрсдэл дагуулдаг.

Улаанбаатар хотын үерийн эрсдэлийг бууруулах энэхүү төсөл нь дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, үерийн гамшгийн тэсвэржилтийг бэхжүүлэх замаар эдгээр сорилт, хүндрэлүүдийг даван туулах зорилготой юм. Гол бүрэлдэхүүн хэсгүүдэд:

1. Үерийн эрсдэл өндөр, нэн шаардлагатай газруудад үерийн хамгаалалтын суваг, далан барих, эвдэрсэн далан, сувгийг сэргээн засварлах.
2. Ариутгах татуургын шугам сүлжээг шинэчлэх, бохир усны шугам хоолойг шуудуу ухалгүйгээр доторлох, шинэчлэх технологийг нэвтрүүлэх.

Энэхүү төслийг хэрэгжүүлснээр нийслэл хотын үерийн эрсдэлийг бууруулж, бохир усны шугам сүлжээг сайжруулж, Улаанбаатар хотын оршин суугчид, ялангуяа эмзэг бүлгийн хүн амын үерийн гамшгийг тэсвэрлэх чадвар, дасан зохицох чадварыг дээшлүүлнэ гэж үзэж байна. Түүнчлэн, уг төсөл нь Монгол Улсын үндэсний хөгжлийн зорилтууд болон Дэлхийн Банкны тогтвортой хот байгуулалтын үүрэг амлалттай нийцэж байгаа юм.

1.1. Бүрэлдэхүүн хэсэг 2: Бохир усны шугам хоолойг шуудуу ухалгүйгээр доторлох, шинэчлэх технологи

“Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газар” ОНӨААТҮГ нь 258’939 м^3/хоног батлагдсан нөөц бүхий 10 эх үүсвэрийн 224 ширхэг гүний худгаас хоногт дунджаар 150’000-170’000 м^3 ус олборлож, сүлжээний 13 усан сан, эх үүсвэрийн 7, дахин дамжуулах 13 насос станц, Ф100/800 мм-ийн голчтой 586 км урт шугам сүлжээ, ус түгээх нийт 689 барилга байгууламжаар дамжуулан нийслэлийн 8 дүүргийн иргэн, аж ахуйн нэгж байгууллагын ард-ахуйн усан хангамжийн хэрэглээг хангаж байна.
Мөн хэрэглээнээс гарсан бохир усыг Ф150/1400 мм-ийн голчтой 281.6 км урт шугам сүлжээ, өргөх 15 насос станц, зөөврийн бохир ус хүлээн авах 5 цэг, нийт 194’910 м3/хоног хүчин чадалтай ахуйн 8 цэвэрлэх байгууламжид хүлээн авч, цэвэршүүлж, стандартын шаардлага хангасан цэвэрлэгдсэн усыг байгальд нийлүүлдэг.



Зураг 1 Улаанбаатар хотын ус хангамжийн шугам сүлжээ



Зураг 2 Улаанбаатар хотын ариутгах татуургын шугам сүлжээ

Өнөөдрийн байдлаар оргил ачааллын үеүдэд ус хангамжийн эх үүсвэрээс олборлон түгээж буй цэвэр усны хэмжээ тогтоосон нөөцийн 70%-д хүрч байгаа бөгөөд мөн нийт олборлон түгээсэн усны 14%-ийг гол болон салбар шугам сүлжээний гэмтэл, усны зүй бус хэрэглээнээс шалтгаалан алдаж байна.
Түүнчлэн хоногт 50’000-60’000 м^3 хөрсний ус ашиглалтын хугацаа дуусан эвдрэл, гэмтэл ихтэй ариутгах татуургын худаг болон шугам сүлжээгээр орж улмаар төв цэвэрлэх байгууламжид хүлээн авч буй бохир усны хэмжээ нь цэвэрлэх байгууламжийн хүчин чадлаас давж байна.
1990 оноос өмнө суурилуулсан бохир усны гол цуглуулах шугамын 50% нь ашиглалтын хугацаа дуусаж, бохир ус нэвтрүүлэх чадвар хүрэлцээгүй болсон нь цэвэрлэгээний түвшинд нөлөөлөн цаашлаад байгаль орчин, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлд сөргөөр нөлөөлж байна.
Төслийн 2-р бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд Улаанбаатар хотын бохир усны шугам сүлжээг өргөтгөн, шинэчлэхэд суваггүй технологийг санал болгож байна, үүнд:

- **Бохир усны шугам** : Ф150 мм-ээс 1000 мм-ийн диаметртэй 50 км бохирын шугам хоолойг сэргээн засварлах/эсвэл шинэчлэх.
- **Худаг** : Нийслэлийн төвийн 6 дүүргийн хэмжээнд байрлах 1056 худгийг доторлох, шинэчлэх

Хуучин шугам хоолойг шуудуу ухахгүйгээр өргөтгөх арга нь бохир усны хоолойг хагалж, хөрсөнд нь шигтгэж (хуучин шугамын сувгийг тэлүүлэн шинээр том диаметртэй хоолой

сүвлэж өргөтгөх), эвдэрсэн хоолойг сэргээх сувгийн доторлогооны технологи юм. Цаашлаад энэхүү арга нь зам талбайг ухаж, эвдрэлд оруулдаггүй, нөхөн сэргээлтийн зардлыг багасгадаг зэрэг давуу талтай.



Зураг 3 Бүрэлдэхүүн хэсэг 2-ын дагуу шинэчлэх, өргөтгөх шугам сүлжээний мэдээлэл

1.2. Санхүүжилтийн хэлбэр

Газар чөлөөлөлт болон нүүлгэн шилжүүлэлтийн үйл ажиллагаанаас бусад төлөвлөж буй төслийн үйл ажиллагааг Дэлхийн Банк санхүүжүүлнэ. Газар чөлөөлөлт болон нүүлгэн шилжүүлэлтийн үйл ажиллагааг санхүүжүүлэх, хэрэгжүүлэх хариуцлага нь зөвхөн Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар (НЗДТГ)-т ногдох болно. Уг үүргийн зааглал нь төслийн үндсэн үйл ажиллагаанд зориулсан санхүүгийн нөөцийг баталгаажуулахын зэрэгцээ, газар чөлөөлөлт болон нүүлгэн шилжүүлэлттэй холбоотой асуудлуудыг үндэсний хууль тогтоомж болон Дэлхийн Банкны Байгаль орчин, нийгмийн стандартын дагуу орон нутгийн захиргаа хариуцах нөхцөлийг бүрдүүлж байна.

1.3. Төсөлд тулгарч болзошгүй хүндрэлүүд

Улаанбаатар хотын хурдацтай хотжилт нь гэр хорооллыг үерийн эрсдэлтэй бүс болон уулын бэл рүү тэлж, хөдөө орон нутгаас шилжин ирэгсэд төлөвлөлтгүй, үерт өртөх өндөр эрсдэлтэй бүсэд суурьшсаар байгаа нь хотын хилийн зааг өргөжихөд нөлөөлж байна. Үүний улмаас үерийн хамгаалалтын цар хүрээ тэлж, урьдчилан сэргийлэх арга хэмжээний ач холбогдол нэмэгдсээр байна.

Улаанбаатар хот нийт 414,292 өрхийн 1,499,140 хүн амтай. Үүний 50.2 хувь буюу 208,049 өрх нь гэр хорооолд амьдарч, 751,157 хүн буюу нийт хүн амын 50.1 хувийг бүрдүүлж байна. Харин үлдсэн 49.8 хувь буюу 206,243 өрх нь орон сууцны хорооолд амьдарч, 747,983 хүн буюу хүн амын 49.9 хувийг эзэлдэг. Хотын нийт газар нутаг 9,752 га бөгөөд гэр хорооллын 23.9 хувь төвийн бүсэд, 28.8 хувь дундын бүсэд, 47.3 хувь нь захын бүсэд тархан байрладаг.

Гэр хорооллын оршин суугчид төвлөрсөн бохирын систем болон дулаан хангамжид холбогдоогүй, дэд бүтцийн дутагдалтай нөхцөлд амьдардаг. Тэд цэвэр усны хангамжаа худаг болон ус түгээх машинаас авч, ариун цэврийн байгууламжаар нүхэн жорлон ашиглаж, халаалт, дулааны хэрэгцээг нүүрс зуух ашиглах замаар хангадаг. Дэлхийн Банкны 2014 оны судалгаагаар гэр хороолол дахь ядуурлын түвшин орон зайн тархалттай гэж дүгнэсэн

байдаг ба гэр хороололд амьдарч буй иргэдийн 38 хувь нь ядуу гэж тодорхойлогдсон бол орон сууцанд амьдарч буй иргэдийн ядуурлын түвшин 1 хувиас бага байна. Түүнчлэн Улаанбаатар хотын ядуу иргэдийн талаас илүү хувь буюу 57.5 хувь нь уламжлалт гэрт амьдардаг байна.

Улаанбаатар хотын хотжилт ихэвчлэн гэр хорооллын хэлбэрээр өргөжин тэлж байгаа ба эдгээр бүсэд ихэвчлэн амьжиргааны түвшнээс доогуур орлоготой иргэд амьдрах хандлага ажиглагддаг. Цаашлаад, гэр хорооллын бүс байгалийн гамшигт өртөх эрсдэл өндөр байдаг учир гэр хорооллын оршин суугчдын тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэхэд дэд бүтцийг сайжруулах, гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр зорилтот арга хэмжээг авах зайлшгүй шаардлагатайг харуулж байна.

Хэдийгээр Газрын тухай хууль (2002), Усны тухай хуулиудад (2012) усны сан бүхий газрын хамгаалалтын бүсэд суурьшихыг хориглодог ч, олон айл өрхүүд эдгээр бүсэд газар эзэмших болон өмчлөх эрхийн гэрчилгээтэйгээр амьдарсаар байна. Усны тухай хууль (2012)-д зааснаар усны сан бүхий газрын эргээс 50 метрээс доошгүй зайд болон гол мөрний татамд онцгой хамгаалалтын бүс тогтоож, тухайн бүсэд айл өрх, аж ахуйн нэгж, байгууллага ямар нэгэн барилга байгууламж барихыг хориглодог. Мөн Байгаль орчин, аялал жуулчлалын сайд болон Барилга, хот байгуулалтын сайдын 2015 оны хамтарсан тушаалаар "Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам"-ыг баталж, дараах байдлаар хамгаалалтын бүсийг тогтоосон байдаг.

- Нуур, урсцын тохируулгатай усан сангийн эргээс 100 метрээс доошгүй зайд
- Хот суурин газрын нутаг дэвсгэр дэх усны сан бүхий газрын эргээс 200 метрээс доошгүй зайд
- Үерийн хамгаалалтын далангаас 100 метрээс доошгүй зайд
- Үерийн хамгаалалтын суваг, түүний хамгаалалтын далангаас 30 метр хүртэлх зайд.

Энэ нөхцөл байдал нь төслийн өртгийг нэмэгдүүлэх, хугацаа хэтрэх эрсдэлийг бий болгож, хэрэв зохих ёсоор шийдвэрлэгдэгүй тохиолдолд нийгмийн ноцтой сөрөг нөлөөлөл үүсгэж болзошгүй юм. Төслийн төлөвлөлт, үнэлгээний үе шатанд нөлөөллийг урьдчилан тодорхойлох нь чухал бөгөөд төслийн төлөвлөлтөд урьдчилан сэргийлэх арга хэмжээг оновчтой тусгаж, төслийг илүү үр дүнтэй, тогтвортой хэрэгжүүлэхэд дөхөм болно.

2. БОННҮ-ний зорилго ба хамрах хүрээ

2.1. БОННҮ-ний зорилго

Энэхүү Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний (БОННҮ) зорилго нь “Улаанбаатар хотын үерийн эрсдэлийг бууруулах” төслийн хүрээнд үүсэж болзошгүй байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийг тодорхойлж, Дэлхийн банкны Байгаль орчин, нийгмийн стандартууд (БОНС 1-10) болон Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцсэн сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг боловсруулахад оршино. Үүнд:

- Төслийн үйл ажиллагаанаас үүдэлтэй биологийн олон янз байдал, усны нөөц, олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдалд учирч болзошгүй эрсдэл, сөрөг нөлөөлөл, үр дагаврыг тодорхойлох, тухайлбал бохир усны шугам хоолойг шуудуу ухалгүйгээр доторлох, шинэчлэх технологи г.м.
- Эрсдэл, нөлөөллийг бууруулах шаталсан аргазүйтэй (зайлсхийх, бууруулах, арилгах, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах) нийцсэн сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээнүүдийг боловсруулах. Эрсдэл, нөлөөллөөс зайлсхийх арга хэмжээг нэн тэргүүнд тавих үүднээс төслийн загварчлалын үе шатанд хувилбаруудыг хэрхэн авч үзсэнийг тусад нь харуулах.
- Гидрологийн болон уур амьсгалын загварчлалыг төслийн төлөвлөлтөд тусгаж, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэрлэх чадварыг сайжруулах.

- Төслийн нөлөөлөлд өртөж болзошгүй иргэдийн амьдралын чанарт үзүүлэх нөлөөллийг үнэлж, ялангуяа зорилтот бүлгийн иргэдийн амьжиргааны түвшинг сэргээх эсвэл сайжруулах чиглэлээр Дэлхийн Банкны стандартад нийцсэн зөвлөмж боловсруулах.
- Олон нийтийн оролцоог хангах зорилгоор тодорхой хүн амын бүлэг орхигдох, ялгаварлагдах эрсдэлийг үнэлж, оролцогч талуудтай зөвлөлдөх уулзалт хийж, газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтээс үүдэж болзошгүй нөлөөллийг бууруулах арга хэмжээг боловсруулах.
- Улаанбаатар хотод хэрэгжиж буй болон төлөвлөгдөж буй дэд бүтцийн төслүүдтэй уялдсан хам болон давхардмал сөрөг нөлөөллийг тодорхойлж, дүн шинжилгээ хийх замаар хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ хийх.

2.2. БОННҮ-ний хамрах хүрээ

Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (БОННҮ) нь “Улаанбаатар хотын үерийн эрсдэлийг бууруулах төсөл”-ийн хүрээнд үүсэж болзошгүй байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийг цогцоор нь үнэлэх ба дараах цар хүрээг хамарна:

Газарзүйн хамрах хүрээ

БОННҮ нь төслийн бүх бүрэлдэхүүн хэсгүүдийг хамарна, үүнд:

- **Бохир усны шугам хоолойг шуудуу ухалгүйгээр доторлох байршил:** Улиастай , Сэлбэ, Био-Сонгино-Туул, Толгойт, Тахилт голуудын бүс нь хүн амын нягтаршил ихтэй, үерт өртөмтгий тул үерийн эрсдэлийн менежментэд чухал ач холбогдолтой гэж тодорхойлсон.
- **Хамгаалалтын бүсүүд**: Холбогдох хууль, журмуудад зааснаар шугамаас 2 тийш 6 метр хүртэлх газар.
- **Дэд бүтэц** : Төслийн үйл ажиллагаа шууд болон шууд бусаар нөлөөлж болзошгүй бохир ус цэвэрлэх байгууламж, усан сан, худаг, насос станцууд.
- **Барилгын талбайнууд**: бохир усны шугам доторлох бүсүүд, чулуу, элс, шороо, хайрга, дайрга олборлолтын талбай, карьерууд, хог хаягдлын цэг зэрэг төслийн нөлөөлөлд өртөж болзошгүй бүх газар.
- **Нүүлгэн шилжүүлэлт хийж болзошгүй байршлууд**: Нийгэм, эдийн засгийн хувьд эмзэг буюу газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлт хийж болзошгүй байршлууд,

Төслийн зураг төсөл, газарзүйн хамрах хүрээнд аливаа өөрчлөлт гарсан тохиолдолд шинэчилсэн зураг төсөлд тусгагдсан бүс нутгийн дагуу БОННҮ-г шинэчилнэ.

Үндсэн хэмжигдэхүүн

БОННҮ доор дурдсан голлох хэмжээсүүдийг хамарна.

- **Байгаль орчин**:
  - Физик: Агаарын чанар, хөрсний чанар, усны чанар, гидрологи, геологи.
  - Биологийн: Биологийн олон янз байдал, нэн чухал амьдрах орчин, голын эрэг орчмын экосистем, түүний дотор ургамал, амьтны аймгийн судалгаа.
- **Нийгэм, эдийн засаг**:
  - Төслийн нөлөөлөлд өртөж болзошгүй иргэдийн төсөөллийн үнэлгээ, газар эзэмшлийн байдал, орон сууцны байдал, нүүлгэн шилжүүлэлтийн хувилбар зэрэг газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлттэй холбоотой нөлөөлөл.
  - Төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн хүн амын амьжиргаа, орлогын эх үүсвэр, орлогын байдал, төслөөс иргэдийн амьжиргаа, амьдралын чанарт үзүүлж болзошгүй нөлөөлөл.
  - Төслийн нөлөөллийн бүсэд байгаа иргэдийн нийгмийн үйлчилгээний хүртээмж болон төслөөс үзүүлж болзошгүй нөлөөлөл. Үүнд үндсэн дэд бүтэц (цахилгаан,

дулаан, цэвэр ус, бохир ус гэх мэт), зам тээвэр, нийтийн болон нийгмийн үйлчилгээ (сургууль, эрүүл мэнд, нийгмийн болон хотын үйлчилгээ гэх мэт).
  - Нийгмийн зорилтот бүлгийн үнэлгээ – хүн амын аль бүлгийг эмзэг гэж үзэж болох, төсөл хэрэгжих бүсэд байгаа тэдгээр иргэдийн хэрэгцээ, тэргүүлэх чиглэлүүд (үүнд шилжин суурьшигчид, зөвшөөрөлгүй өрхүүд, өндөр настан, өрх толгойлсон эцэг эх, ядуурлын шугам буюу амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэд, ажилгүйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон тэдний асран хамгаалагчид багтана.)
  - Төслийн бүх үе шатанд олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдалд учирч болзошгүй эрсдэл ба нөлөөлөл.
  - Бэлгийн мөлжлөг, хүчирхийлэл, бэлгийн дарамт зэрэг жендертэй холбоотой эрсдэлүүд; эдгээртэй холбоотой тохиолдол, гомдолд хариу өгөх үйлчилгээний хүртээмжийн үнэлгээ.
  - Төслийн ажиллах хүчний хэрэгцээ, хөдөлмөрийн эрсдэл ба нөлөөлөл, түүний дотор хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, хүн амын шилжилт хөдөлгөөнөөс үүдэлтэй эрсдэл болон бусад холбогдох эрсдэлүүд.
  - БОННҮ-г боловсруулах явцад зохион байгуулах төслийн оролцогч талуудын оролцоог хангах арга хэмжээнүүд, хэлэлцүүлэг, уулзалтууд, олон нийтэд мэдээлэх аргачлал болон талуудын оролцоог цаашид хэрхэн хангах төлөвлөлт

Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний хамрах хүрээ

Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (БОННҮ) нь төслийн нөлөөллийн нарийвчилсан, иж бүрэн үнэлгээг баталгаажуулахын тулд дараах өргөтгөсөн хамрах хүрээний элементүүдийг хамарна.

- **Өргөтгөсөн үнэлгээний талбарууд**:
  - Төсөлтэй холбоотой карьерын талбай, хөрс олборлолтын талбай, хог хаягдлын цэг, тээврийн маршрут зэргийг оруул. Байршил бүрийн байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийг үнэл.
  - (ЦБС), ус шахах станц зэрэг туслах байгууламжуудын байгаль орчин, нийгмийн стандартад нийцэж байгаа эсэх, тэдгээрийн болзошгүй хуримтлагдах нөлөөллийг үнэлэхийн тулд зохих шалгалт хийх.
- **Гидрологийн мэдээлэл**:
  - Техник эдийн засгийн үндэслэлийн тайлангийн (ТЭЗҮ) багаас ирүүлсэн ус судлалын мэдээлэл болон үерийн эрсдэлийн загварчлалыг нэгтгэх. Энэ өгөгдлийг голын морфологи, гүний усны нөөц, хурдас тээвэрлэлт, үерийн ерөнхий динамик байдалд үзүүлэх нөлөөллийг шинжлэхэд ашигласнаар төсөл нь ус зүйн сөрөг өөрчлөлт оруулахгүйгээр тэсвэрлэх чадварыг дээшлүүлнэ.
- **Нөлөөллийн үнэлгээ:**
  - **Шууд ба шууд бус нөлөөлөл**: Барилгын болон үйл ажиллагааны үе шатад байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөө
  - **Хуримтлагдах нөлөөлөл**: Төслийн бүрэлдэхүүн хэсгүүд болон одоо хэрэгжиж байгаа эсвэл төлөвлөж буй бусад төслүүдээс хүн амын эрүүл мэндэд үзүүлж байгаа хам болон давхардмал сөрөг нөлөөлөл
  - **Үлдэгдэл нөлөөлөл** : Нөлөөллийг бууруулах боломжит бүх арга хэмжээг хэрэгжүүлсний дараах үлдэж буй төслийн нөлөөлөл.

Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ

БОННҮ-нд байгаль орчин, нийгмийн асуудлыг илүү өргөн цар хүрээнд авч үзэх шаардлагатай тул хуримтлагдсан нөлөөллийн үнэлгээ багтаж байна.

- Харилцан уялдаатай төслүүдийн шинжилгээ:
  - Одоо хэрэгжиж буй болон төлөвлөгдсөн дэд бүтцийн төслүүд (жишээ нь, бохир ус цэвэрлэх байгууламжууд, усан сангууд, хот байгуулалтын төслүүд болон авто замын сүлжээнүүд) болох хуримтлагдах нөлөөллийн эх үүсвэрүүд нь төсөлтэй хэрхэн хуримтлагдах нөлөөлөл үүсгэхийг тодорхойлж, үнэлэх.

- Нөлөөллийн бүсүүдийн давхцал бүхий талбайнуудыг тодорхойлох, хамтран ашиглагдах нөөцүүд (жишээ нь, ус, газар) болон нийтлэг байгаль орчин, нийгмийн эрсдэлүүдэд анхаарах.
- Мастер төлөвлөгөөний тойм:
  - *Хотын инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөө (2023 он)*, *Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө: Инженерийн бэлтгэл арга хэмжээ (2021 он)* болон бусад холбогдох үерийн хамгаалалтын стратеги, усны менежментийн төлөвлөгөө болон бүс нутгийн хөгжлийн төлөвлөгөөнүүдийг хянах.
  - Төлөвлөж буй төсөл болон бусад хөгжлийн төслүүдийн харилцан үйлчлэлээс үүсэх эерэг (жишээ нь, экосистемийн үйлчилгээ сайжрах) болон сөрөг нөлөөг (жишээ нь, газрын ашиглалтын давхцал) тодорхойлох.
  - Төслийн зорилго болон бүс нутгийн төлөвлөлтийн зорилгод нийцүүлэн, хуримтлагдсан сөрөг нөлөөллийг багасгах, зорилтуудыг уялдуулах нэгдсэн менежментийн шийдлүүдийг санал болгох.

Шуудуу ухалгүйгээр бохир усны шугам хоолойг доторлох, шинэчлэх технологи

Бүрэлдэхүүн хэсэг 2-ын хүрээнд бохир усны шугам, сүлжээний шинэчлэлд ашиглах шуудуугүй технологи нь суваг ухдаг уламжлалт арга барилтай харьцуулахад байгаль орчин, нийгмийн нөлөөллийн хувьд харьцангуй давуу талтай. Тухайлбал, хөрсний эвдрэл буурч, эрчим хүчний хэрэглээг хэмнэж, технологи ашиглалтын явцад газар ашиглалтын хязгаарлалт хийх хүрээ хамгийн бага байдгаараа давуу талтай. Уг технологийг ашигласнаар барилга угсралтын явцад газрын гадаргад үзүүлэх эвдрэл, сөрөг нөлөө ихээхэн буурч, зам хаах болон замын хөдөлгөөнд саад учруулах нөлөө хамгийн бага түвшинд байдаг.

Гэсэн хэдий ч тухайн технологийн хэрэглээнээс шалтгаалж зарим нийгмийн сөрөг нөлөө үүсэж болзошгүй. Барилгын талбайн орчмын орон сууц, суурьшлын бүсэд нэвтрэх замд түр хязгаарлалт хийх, цаашлаад хүнд даацын машин, механизмын хөдөлгөөнөөс хамаарч замын хөдөлгөөнд саатал үүсэх зэрэг хөнгөн сөрөг нөлөө үүсэх магадлалтай. Эдгээр болзошгүй нөлөөллийг арилгахын тулд Түр замын хөдөлгөөний менежментийн төлөвлөгөө (ТЗХМТ) боловсруулж, тойруу замууд, замын тэмдэг тэмдэглэгээ, мөн замын хөдөлгөөний оргил ачааллын үед ажлын хуваарьт зохицуулалт хийх г.м арга хэмжээнүүдийг багтаах шаардлагатай.

Хэдийгээр үндэсний байгаль орчны нөлөөллийн үнэлгээтэй холбоотой хууль, журмын хүрээнд шуудуугүй технологийн үнэлгээ шаардлагагүй гэж үзэж болох ч төслийн БОННҮ-ий хамрах хүрээнд уг технологийг багтааснаар төслийн байгаль орчин, нийгмийн нөлөөллийг илүү цогц байдлаар үнэлэх боломжтой болох юм.

Нийгмийн суурь мэдээлэл ба нөлөөллийн үнэлгээ

Нийгмийн суурь мэдээлэл болон нөлөөллийн үнэлгээ нь бохир усны 40 км шугамын дагуу байрлах дүүргүүдийн нийгэм, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдэд төвлөрнө[1].

- Баянзүрх дүүрэг
- Сүхбаатар дүүрэг
- Сонгинохайрхан дүүрэг
- Хан уул дүүрэг

[1] *Эдгээр байршлууд нь урьдчилсан байдлаар хийгдсэн бөгөөд ТЭЗҮ боловсруулах багаас өгсөн эцсийн байршилд үндэслэн үнэлгээ хийнэ. Төслийн дизайн эсвэл газарзүйн хамрах хүрээнд ямар нэгэн өөрчлөлт гарсан тохиолдолд БОННҮ-д шинэ байршлуудыг тусган шинэчилнэ.*

- Баянгол дүүрэг
- Баянзүрх дүүрэг

Нийгмийн нөлөөллийн үнэлгээгээр төслийн нөлөөлөлд өртөж болзошгүй иргэд, түүний дотор эмзэг, өртөмтгий зорилтот бүлгийг тодорхойлж, тэдний амьжиргаа, нийгмийн үйлчилгээ, хотын дэд бүтцийн хүртээмжид үзүүлж болзошгүй эрсдэл, нөлөөллийг үнэлнэ. Судалгааны цогц байдлыг хангах зорилгоор санал асуулга, бүлгийн хэлэлцүүлэг, оролцогч талуудын зөвлөлдөх уулзалтуудыг зохион байгуулна.

Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтэд өртөж болзошгүй бүсүүд

Энэхүү үнэлгээг нөлөөлөлд өртсөн иргэдэд шударга нөхөн олговор олгох, амьжиргааг сэргээх, нийгэм, эдийн засгийн сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах үүднээс Дэлхийн банкны БОНС5 (Газар чөлөөлөх, газар ашиглахыг хязгаарлах, албадан нүүлгэн шилжүүлэх) стандарттай нийцүүлнэ. Тооллогын судалгаа, хөрөнгийн үнэлгээ нь нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөлтийн үндэс болно.

Уугуул иргэд ба үндэсний цөөнхийн асуудлыг авч үзэх нь

БОННҮ-ны хүрээнд төслийн бүсэд Уугуул иргэд болон үндэсний цөөнх оршин байгаа эсэхийг тодорхойлж, үнэлгээ хийх шаардлагатай бөгөөд энэ нь ESS7 стандартад нийцүүлэн хийгдэнэ. Үүнд эдгээр иргэдийн нийгэм, соёл, эдийн засгийн онцлог шинж чанар болон төслийн үйл ажиллагаанд өртөж болзошгүй эмзэг байдлыг үнэлэх үйл явц багтана.

3. Бодлого, хууль эрхзүйн орчин

Тус төслийн БОННҮ (Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ)-г боловсруулах явцад үндэсний хууль тогтоомж болон Дэлхийн Банкны стандартыг мөрдөн ажиллах бөгөөд байгаль орчин, нийгмийн эрсдэлийг цогцоор нь тодорхойлох, үнэлэх зарчим баримтална. Үндэсний түвшинд мөрдөгдөх гол эрх зүйн зохицуулалтуудад Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (2012) болон ус, хатуу хог хаягдал, газар, соёлын өвийг зохицуулсан салбарын хууль тогтоомжууд багтана. Үүнээс гадна, Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журамд (Засгийн газрын 2023 оны 58 дугаар тогтоол) заасан тусгайлсан шаардлагуудыг удирдлага болгоно. Нийгмийн нөлөөллийн үнэлгээний хувьд газрын эзэмшил, газар ашиглалтын зохицуулалтын чиглэлээр Газрын тухай хууль (2002) болон Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль (2015) нь төслийн үйл ажиллагаанаас үүдсэн нүүлгэн шилжүүлэлтийн нөлөөллийг удирдах гол зохицуулалтууд юм.
Олон улсын түвшинд Дэлхийн Банкны Байгаль орчин, нийгмийн стандартууд (БОНС1–10)-ыг мөрдөн хэрэгжүүлэх бөгөөд хөдөлмөрийн нөхцөл, нөөцийн үр ашигтай байдал, биологийн олон янз байдал, оролцогч талуудын оролцоог хангах зохицуулалт, шаардлагуудыг багтаасан байдаг. Мөн Дэлхийн Банкны аж үйлдвэрийн салбарын удирдамжууд, үүнд Ус ба ариун цэврийн байгууламжийн удирдамж (2007 он)-д заасан шаардлагуудыг тусган ажиллана.
Түүнчлэн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нь Дэлхийн Банкны нийтлэг хүлээн зөвшөөрөгдсөн гүйцэтгэлийн түвшин болон арга хэмжээг тодорхойлдог Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны удирдамж (БОЭМААУ)-д нийцүүлэн ажиллах шаардлагатай. Монгол Улсын дотоодын холбогдох журам, стандартуудад заасан шаардлагууд БОЭМААУ - уудад заасан шаардлагаас зөрүүтэй байгаа тохиолдолд илүү хатуу стандартыг нь мөрдлөг болгох

шаардлагатай. БОЭМААУ-ийн стандартуудыг мөрдөх нь техникийн болон санхүүгийн хувьд хүндрэлтэй гэж үзсэн тохиолдолд, зөвлөх үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь байгаль орчин, нийгмийн үнэлгээгээр дамжуулан орлуулах боломжтой гүйцэтгэлийн арга хэмжээг санал болгох үндэслэлийг дэлгэрэнгүй тайлбарлах ёстой. Тухайн үндэслэлд зөвлөх үйлчилгээ үзүүлэгчийн зүгээс санал болгож буй арга хэмжээ нь Дэлхийн Банкны БОНС

болон БОЭМААУ-ийн зорилготой нийцэж байгааг, мөн байгаль орчин, нийгэмд ноцтой хохирол учруулахгүй гэдгийг тайлбарласан байх шаардлагатай.
БОННҮ-г боловсруулахад хамаарах үндэсний хууль, тогтоомжууд болон Дэлхийн Банкны стандартууд дараах байдалтай байна.

3.1. Дэлхийн банкны байгаль орчин, нийгмийн стандартууд (БОНС)

БОНС1: Байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийн үнэлгээ, менежмент

БОНС 1-ийн хүрээнд төсөл хэрэгжиж эхлэхээс төсөл хаагдах хүртэл бүхий л хэрэгжилтийн явцад үүсэж болзошгүй байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийг нарийвчлан тогтоож, цогц үнэлгээ хийж, бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэхийг шаарддаг. Үүнд, төслийн үйл ажиллагаанаас үүдсэн олон нийтийн эрүүл мэнд, экосистем, бусад нийгмийн хүчин зүйлсийн эрсдэлийг удирдахад чиглэсэн арга хэмжээнүүдийн төлөвлөгөө боловсруулах багтдаг.

БОНС 2: Хөдөлмөрийн болон ажиллах нөхцөл

ДБ нь БОНС 2-ийн хүрээнд ажилчдыг эрх тэгш, аюулгүй хөдөлмөрийн нөхцөлөөр хангах, хөдөлмөрлөх эрхийг дээдлэх, албадан болон хүүхдийн хөдөлмөрөөс урьдчилан сэргийлэхийг зорьдог бөгөөд ажилчдын эрх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хамгаалах арга хэмжээ, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөлүүдийг тодорхой зааж, хөдөлмөрийн харилцаатай холбоотой асуудлыг шийдвэрлэх гомдол гаргах, барагдуулах механизмыг тусгасан байдаг.

БОНС 3: Байгалийн нөөцийн зохистой ашиглалт, хүрээлэн буй орчны бохирдлын урьдчилан сэргийлэлт ба менежмент

БОНС 3 нь төслийн бүхий л үе шатад байгалийн нөөцийг үр ашигтай ашиглах, бохирдлыг бууруулах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд төвлөрдөг. Үүнд хог хаягдлыг менежмент хэрэгжүүлэх, хүлэмжийн хийн ялгарлыг багасгах, байгалийн нөөцийг тогтвортой ашиглах, байгаль орчны доройтлоос урьдчилан сэргийлэх, бууруулахад чиглэсэн зохих арга хэмжээг авах зэрэг багтана.

БОНС 4: Нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдал

БОНС 4 нь олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, ялангуяа төслийн нөлөөлөлд өртсөн бүс нутгуудад чиглэдэг. Энэ нь аливаа барилгын үйл ажиллагаатай холбоотой эрсдэл, замын хөдөлгөөний саатал, болзошгүй аюул, ослыг багасгахад анхаарч, төслийн үйл ажиллагаанаас үүдэлтэй дуу чимээ, агаарын бохирдол, эрүүл мэндийн эрсдэл зэрэг сөрөг нөлөөллөөс орон нутгийн иргэд, олон нийтийг хамгаалахад чиглэгддэг.

БОНС 5: Газар чөлөөлөлт, газар ашиглалтад тавих хязгаарлалт ба албадан нүүлгэн шилжүүлэлт

БОНС 5 нь газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх үйл явцын шударга, ил тод байдалд анхаарч, нөлөөлөлд өртсөн иргэдийн нөхөн олговортой холбоотой харилцааг зохицуулдаг. Уг стандартын хүрээнд нүүлгэн шилжүүлэлтээс зайлсхийх, багасгах, нөлөөлөлд өртсөн иргэдийн амьжиргааг сэргээх, нийгмийн эмзэг, өртөмтгий зорилтот бүлгийг хамруулах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх шаардлагыг тусгасан байдаг ба төслүүдээс газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтээс үүдэж болзошгүй нийгмийн сөрөг нөлөөллийг арилгах, багасгахад чиглэсэн зөв төлөвлөлтийг шаарддаг.

БОНС 6: Биологийн олон янз байдлыг хамгаалах, амьд байгалийн нөөцийн тогтвортой менежмент

БОНС 6 нь биологийн олон янз байдлыг хамгаалах, амьд байгалийн нөөцийн тогтвортой менежментэд чиглэдэг ба экосистем, биологийн олон янз байдал, ялангуяа байгаль экологийн хувьд эмзэг бүс нутагт үзүүлэх нөлөөллийг үнэлэх, ан амьтан, байгалийн амьдрах орчин, байгалийн нөөцөд учирч буй хохирлыг багасгах стратегийг хэрэгжүүлэхийг төслүүдийг шаарддаг.

БОНС 7: Уугуул иргэд/ Африкийн Өмнөд Сахар орчмын үе дамжин орхигдсон уламжлалт орон нутгийн иргэд

БОНС 7 нь үндэсний цөөнх болон нутгийн уугуул иргэдийн эрх, өвөрмөц онцлог, соёлын өвийг хүндэтгэхийг зорьдог. ДБ энэхүү стандартыг хүн амын олонхтой харьцуулахад өвөрмөц хэл аялга, соёлын зан заншил, эсвэл уламжлалт амьдралын хэв маяг бүхий, ихэвчлэн өвөг дээдсийн газар нутаг эсвэл байгалийн нөөцөд тулгуурлан амьдардаг бүлгүүдэд хэрэглэдэг. Эдгээр бүлгүүд хөгжлийн төслүүдийн үр шимээс хоцрох эсвэл сөрөг нөлөөлөлд харьцангуй хэлбэрээр өртөх магадлалтай учир эмзэг байдаг.
БОНС 7 нь эдгээр иргэдэд сөрөг нөлөөлөл учруулахаас зайлсхийх эсвэл бууруулах, хүртээмжтэй хөгжлийг дэмжих, мөн эдгээр хүн амын бүлгүүдийн эрх, газар нутаг эсвэл байгалийн нөөцөд ихээхэн нөлөөлөх үйл ажиллагаанд тэдний "Таниулсан зөвшөөрөл" (ТЗ)-ийг авахыг чухалчилдаг.

БОНС 8: Соёлын өв

ESS 8 нь биет болон биет бус соёлын өвийг хамгаалах, хадгалах асуудлыг хөнддөг. Төслүүд соёлын дурсгалт газрууд, зан үйл, уламжлалд үзүүлэх нөлөөллийг үнэлж, соёлын өвийг хамгаалах, хадгалах, зохистой удирдах арга хэмжээг орон нутгийн ёс заншлын дагуу хэрэгжүүлэх шаардлагатай. Мөн соёлын өвд үзүүлэх боломжит нөлөөллийг эрт тодорхойлж, хор хөнөөлийг бууруулах арга хэмжээ авах, төслийг хэрэгжүүлэх явцад гэнэтийн олдвор илэрсэн тохиолдолд баримтлах журам, тухайлбал, "гэнэтийн олдворын протокол"-ыг тодорхой болгохыг шаарддаг.

БОНС 9: Санхүүгийн зуучлагчид (СЗ)

БОНС9 нь Санхүүгийн зуучлагч (СЗ) болон санхүүгийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой байгаль орчин, нийгмийн эрсдэлийн менежментэд чиглэдэг. Төсөлд ихэвчлэн банк, бичил санхүүгийн байгууллага эсвэл бусад санхүүгийн үйлчилгээний байгууллагууд зэрэг санхүүгийн салбар дахь дэд төсөл эсвэл бизнест санхүүжилт, зээл олгодог санхүүгийн зуучлагчдыг хамруулсан тохиолдолд уг стандарт хэрэгждэг.
“Улаанбаатар хотын үерийн эрсдэлийг бууруулах төсөл”-ийн хувьд БОНС9 дараах шалтгааны улмаас хамаарахгүй болно.

- Санхүүгийн зуучлагч оролцоогүй: Төсөлд гуравдагч талын дэд төслүүдийг санхүүжүүлэх банк, хөрөнгө оруулалтын сан, санхүүгийн байгууллага зэрэг санхүүгийн зуучлагчдыг оролцуулаагүй болно. Бусад бизнес, салбарыг санхүүжүүлэх, зээл олгоход санхүүгийн зуучлагчдыг татан оролцуулах шаардлагагүй, үерийн аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг багтаасан дэд бүтцийг хөгжүүлэхэд төслийн зорилго чиглэж байна.
- Үерийн дэд бүтцийг шууд хэрэгжүүлэх: Төсөл нь голчлон далан, бохир усны шугамыг шинэчлэх зэрэг үерийн аюулаас урьдчилан сэргийлэх дэд бүтцийг шууд барьж байгуулах бөгөөд бусад аж ахуйн нэгж, төслийг зээл, хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх, дэмжихэд чиглээгүй. Иймд санхүүгийн үйлчилгээ болон дэд төслүүдийн байгаль орчин, нийгмийн эрсдэлийн менежменттэй холбоотой БОНС9-ийн шаардлага хамаарахгүй.
- СЗ-ийн үйл ажиллагаанаас үүдэлтэй байгаль орчны болон нийгмийн эрсдэл байхгүй: БОНС9 нь санхүүгийн зуучлагчдын хийсэн хөрөнгө оруулалтаас үүдэлтэй шууд бус нөлөөлөл байж болзошгүй санхүүжилтийн үйл ажиллагаатай холбоотой эрсдэлүүдийг тусгайлан авч үздэг. Төслийн үйл ажиллагаа нь санхүүгийн үйл

ажиллагаа гэхээсээ илүүтэй биет дэд бүтцийн бүтээн байгуулалтаар хязгаарлагдах тул БОНС9-д хамаарах хөрөнгө оруулалтаас үүсэх эрсдэл байхгүй.

БОНС 10: Талуудын оролцоо ба мэдээллийн ил тод байдал

БОНС 10 нь төслийн бүх үе шатанд оролцогч талуудтай ил тод харилцааг бий болгох, мэдээллийг цаг алдалгүй түгээхийг чухалчилдаг. Энэхүү арга барил нь орон нутгийн иргэдийг сайн мэдээлэлтэй байлгаж, шийдвэр гаргах үйл явцад идэвхтэй оролцох боломжийг олгодог. Үр дүнтэй хамтын ажиллагааг эрхэмлэснээр БОНС 10 нь төсөл хэрэгжүүлэгч болон орон нутгийн иргэдийн итгэлцлийг бэхжүүлж, иргэдийг төслийн үйл ажиллагаанд өөрсдийн дуу хоолойг хүргэж, төслийн үр дүнд нөлөө үзүүлэх боломжоор хангахын зэрэгцээ зөрчилдөөн үүсэхээс урьдчилан сэргийлж, оролцогч талуудыг тэгш, хүртээмжтэй үр шим хүртэх нөхцөлөөр хангадаг.

Дэлхийн Банкны Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны удирдамж

- БОЭМАА-ны ерөнхий удирдамж (2007)
    1. Байгаль орчин
    2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
    3. Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал
    4. Барилга угсралтын болон буулгалтын үйл ажиллагаа

Аж үйлдвэрийн салбарын удирдамж

- Ус ба ариун цэврийн байгууламж (2007)
- Хог хаягдлын менежментийн байгууламж (2007)
- Барилгын материалын олборлолт (2007)

3.2. Монгол Улсын хууль тогтоомж

Байгаль орчны

- Усны тухай хууль (2012)
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (2012)
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль (1995)
- Агаарын тухай хууль (2012)
- Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль (2010)
- Гамшгаас хамгаалах тухай хууль (2017)
- Соёлын өвийг хамгаалах тухай хууль (2014)
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль (2008)
- Хөдөлмөрийн тухай хууль (2021)
- Газрын тухай хууль (2002)
- Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль (2012)
- Хог хаягдлын тухай хууль (2017)
- Амьтны тухай хууль (2012)
- Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль (1994)

Нийгмийн

- Газрын тухай хууль (2002)
- Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль (2002)
- Хөрөнгийн үнэлгээний тухай хууль (2022)
- Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль (2015)
- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль (2018)
- Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль (2023)

Журам, тушаал

Байгаль орчны

- Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам (Засгийн газрын 2023 оны 58 дугаар тогтоол)
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журам (БОАЖСайдын 2014 оны А-03 тоот тушаал)
- Байгаль орчны хохирлын үнэлгээ, нөхөн төлбөр тооцох аргачлал (БОАЖ Сайдын 2014 оны А-156 тоот тушаал)

Нийгмийн

- Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх журам (Засгийн газрын 2024 оны 91 дүгээр тогтоол)
- Хотыг суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны нөхөн олговор олгох журам (Засгийн газрын 2018 оны 222 дугаар тогтоол)
- Газрын үнэлгээний тойрог, зэрэглэл (бүс), суурь үнэлгээ, газрын төлбөрийн хэмжээг тогтоох тухай (Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоол)
- Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах, түүний хэмжээ, заагийг тогтоох, ашиглах журам (Засгийн газрын 2017 оны 287 дугаар тогтоол)
- Газар, үл хөдлөх эд хөрөнгийн нөхөх олговрын зориулалттай үнэлгээний аргачлал (Сангийн Сайд, БХБСайдын 2020 оны 202/196 тоот хамтарсан тушаал)
- Барилга байгууламжийн нэгж хүчин чадлын жишиг үнэлгээг хэрэглэх дүрэм (БХБСайдын 2016 оны 203 тоот тушаал)
- Нийслэлийн Газрын эрхийн маргаан таслах зөвлөлийн ажиллах журам, бүрэлдэхүүн батлах тухай (Засгийн газрын 2024 оны 90 дүгээр тогтоол)

4. Гүйцэтгэх ажлын тойм

4.1. Төслийн бүрэлдэхүүн хэсгийн шинжилгээ ба хураангуйг бэлтгэх

Зөвлөх нь Техник-эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ)-ийн багтай нягт хамтран ажиллаж, төсөлд чухал ач холбогдолтой мэдээллийг цуглуулах, нэгтгэх, шинжлэх үүрэгтэй. Ингэснээр төслийн бүрэлдэхүүн хэсгүүд, үйл ажиллагааны талаар тодорхой, нарийвчилсан ойлголттой болох ба энэхүү төслийн бүрэлдэхүүн хэсгүүдийн шинжилгээ ба хураангуй нь байгаль орчин, нийгмийн нөлөөллийн анхан шатны үнэлгээ болон БОННҮ-г боловсруулах суурь болно. Төсөлд чухал чухал ач холбогдолтой мэдээлэлд дараахь зүйлс багтана.

- Үйл ажиллагааны цар хүрээ, хамрах хүрээ, төрөл.
- Газарзүйн байршил, хил хязгаар.
- Дэд бүтцийн зураг төсөл, ашиглалтын тодорхойлолт.

Түүнчлэн байгаль орчин, нийгмийн асуудлыг ТЭЗҮ-ийн тайлангийн төслийн тодорхойлолтод тусгахад анхаарна.

Төслийн хураангуй хүснэгт боловсруулах:

- ТЭЗҮ-ийн багийн өгсөн мэдээлэлд үндэслэн дараах агуулгыг багтаасан хураангуй хүснэгт боловсруулна. Үүнд:
    - Төслийн бүрэлдэхүүн хэсэг болон үйл ажиллагаа.
    - Төсөл хэрэгжих байршлууд ба нөлөөллийн бүсүүд.
    - Байгаль орчин, нийгмийн үнэлгээнд хамаарах үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүд.
- Уг хүснэгтийг, үйл ажиллагаа тус бүрийн болзошгүй эрсдэл нөлөөллийг тодорхойлох БОННҮ-ний анхан шатны үнэлгээнд ашиглана.

4.2. Анхан шатны үнэлгээ ба урьдчилсан дүн шинжилгээ

Зөвлөх нь БОННҮ боловсруулах хүрээнд төслийн үйл ажиллагааны улмаас нөлөөлөлд өртөж болзошгүй бүх бүс нутаг, байршлуудыг хамруулах шаардлагатай. Тухайлбал анхан шатны үнэлгээ нь бохир ус цэвэрлэх байгууламж, усан сан, худаг, насос станцуудыг хамарна. Цэвэрлэх байгууламжийн хувьд лагийн менежмент, бохир усны чанар, байгаль орчны холбогдох стандартад нийцэж байгаа эсэхийг анхан шатны үнэлгээгээр

баталгаажуулна. Усан сан, худаг, насос станцуудын хувьд тус үнэлгээ нь усны чанар, ус ашиглалт, ашиглалтын аюулгүй байдлыг хамруулна.

Мөн үерийн хамгаалалтын суваг, далан, борооны ус зайлуулах шугам сүлжээнд зохих шалгалт, урьдчилсан дүн шинжилгээ хийх ёстой. БОННҮ нь эдгээр байгууламжийн зураг төсөл, цар хүрээ, байршлыг үнэлж, байгаль орчин, нийгэмд учирч болзошгүй нөлөөлөл, түүний дотор усны урсцын өөрчлөлт, зэргэлдээх газрын ашиглалтын эрсдэл, иргэд, олон нийтийн аюулгүй байдалд үзүүлэх нөлөөллийг тодорхойлох ёстой. Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэх эрсдэл зэрэг барилга байгууламжтай холбоотой нөлөөллийг мөн үнэлнэ.

Түүнчлэн БОННҮ-нд Усны тухай хуульд заасан онцгой хамгаалалтын бүс буюу голын эргээс 50 метрийн доторх талбайд байрлах байшин барилгууд, цаашлаад карьерын талбай, хөрс олборлолтын талбай, барилгын хог хаягдлын цэг гэх мэт төслийн нөлөөлөлд өртөж болзошгүй бусад бүсүүдийг хамруулна. Түр барилга байгууламж, тухайлбал, зам, түр талбайн нөлөөллийг тооцон, барилга угсралт болон ашиглалтын үеийн дуу чимээ, тоосжилт, хөдөлгөөний эрсдэлтэй холбоотой эрсдэлүүдийг мөн тодорхойлох шаардлагатай.

Үүнээс гадна, барилгын үйл ажиллагаанаас үүдэлтэй усны чанар, тунадасжилт, иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд үзүүлэх шууд ба шууд бус нөлөөлөл, зэргийг үнэлгээнд хамруулна. Барилгын ажлын явцад хөрс ухах, чулуу олборлох, голын хагшаас зөөвөрлөх зэрэг үйл ажиллагаанаас гарсан хаягдлын менежментэд онцгой анхаарал хандуулж, хаягдал зайлуулахтай холбоотой боломжит нөлөөллийг, үүнд талбай сонголт, хаягдал зайлуулах арга, байгаль орчны стандартыг мөрдөж байгаа эсэхийг нарийвчлан үнэлж, хаягдлын менежментийн боломжит хувилбарыг санал болгоно.

4.3. Байгаль орчны суурь мэдээлэл цуглуулах

Төсөл хэрэгжих бүс нутгийн байгаль орчны суурь мэдээллийг цуглуулах нь тухайн бүсийн байгаль орчны өнөөгийн төлөв байдлын талаар иж бүрэн ойлголтыг бий болгодог бөгөөд төслийн болзошгүй сөрөг нөлөөллийг үнэлэх, бууруулах арга хэмжээг төлөвлөх үндэс суурь болдог**.** Суурь мэдээлэл цуглуулахдаа төсөл хэрэгжих бүс нутгийн физик, биологи, нийгэм, эдийн засгийн дараах хүчин зүйлүүдтэй холбоотой мэдээллийг багтаана.

Физик-газарзүй

- Төслийн бүс нутгийн гол шинж чанаруудыг харуулсан газрын зураг, орон зайн мэдээллийг боловсруулах

Топограф (газрын гадарга, газарзүйн тогтоц)

- Топографийн судалгаа явуулж, төсөл хэрэгжих бүс нутгийн өндөр, налуу, газар нутгийн өөрчлөлтүүдийг тодорхойлох. Энэ нь хөрсний эвдрэл болон усны үерийн аюултай бүс нутгуудыг ойлгоход чухал ач холбогдолтой.
- Газар нутгийн налуу, өндөрлөг хэсгийг тодорхойлж, үерийн аюултай болон хөрсний нуралт үүсэх боломжтой бүсүүдийг илрүүлэх зорилгоор гадаргын өндөржилтийн зургийг боловсруулна.

Геологи ба Геоморфологи

- Төслийн талбайн геологийн ерөнхий онцлогийг товч дүгнэн гаргаж, тунамал, магмын, болон хувирмал чулуулаг байгаа эсэхэд анхаарна.
- Газар хөдлөл, хөрсний нуралт, тогтворгүй хөрс зэрэг геологийн онцгой эрсдэлтэй бүс нутгийг одоо байгаа судалгаа, өгөгдөлд тулгуурлан тодорхойлно.
- Төслийн талбайн гол геоморфологийн шинж чанаруудыг тодорхойлох (жишээ нь: голын эрэг, үерийн талбай, дэнж).

- Төслийн төлөвлөлт, хэрэгжилтэд нөлөөлж болзошгүй элэгдэл, хуримтлал ихтэй хэсгүүдийг тодорхойлно.

Хөрсөн бүрхэвч

- Хөрсний хэв шинж, физик, химийн шинж чанар (элс, лаг, шавар) болон хөрсний тогтворжилт муутай газруудыг тодорхойлох.
- Хөрсний шинжилгээ нь хөрсний бүтэц, нягтрал, органик агууламжийг хэмжиж, үерээс хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэгдэх ёстой.
- Төсөл хэрэгжих талбайн газрын доройтлын нөхцөл (жишээ нь, элэгдэл, нягтаршил), ялангуяа Сэлбэ, Улиастай, Био-Сонгино-Туул, Толгойт, Тахилт голуудын эрэг орчмын бүсэд тодорхойлох шаардлагатай.

Газар зохион байгуулалтын зураглал

- Төслийн нутаг дэвсгэрийн хамрах хүрээн дэх газар олголт, орон сууц, худалдаа, үйлдвэрлэлийн болон бусад газар ашиглалтын ангиллын тархалтыг харуулсан газар ашиглалтын нарийвчилсан зураг боловсруулах.
- Сэлбэ, Улиастай, Туул, Толгойт, Тахилт голуудын онцгой хамгаалалтын бүсэд өртөж буй газар олголт, эдэлбэр газрын судалгааг хийж, байгаль экологийн чухал ач холбогдолтой, нийгмийн хувьд эмзэг газруудыг тодорхойлж, зураглал хийж, хилийн заагийг тогтоох.
- Газар зохион байгуулалтын зураг нь нүүлгэн шилжүүлэлт, үерийн хамгаалалтын далангийн зурвас, дэд бүтэц г.м төслийн нөлөөлөлд өртөж болзошгүй газрууд болон байгаль экологийн чухал ач холбогдолтой, нийгмийн хувьд эмзэг газруудыг багтаасан байх ёстой.[2]

Уур амьсгал

Зөвлөх компани нь төсөл хэрэгжих байршлуудын ойролцоох цаг уурын станцуудаас цаг уурын мэдээлэл цуглуулж, температур, хур тунадас, салхи, чийгшил болон бусад цаг уурын үзүүлэлтүүдийн суурь үзүүлэлтийг тогтооно.

- Температур: Дундаж температурын хэлбэлзэл
- Хур тунадас: Жилийн нийт хур тунадас, ялангуяа хамгийн их хур тунадас ордог саруд болон цаг агаарын аюулт болон гамшигт үзэгдлийн давтамж
- Салхины горим: Хавар, намрын улиралд ажиглагддаг ердийн салхины хурдны өгөгдөл.
- Уур амьсгалын бусад хүчин зүйлс: Цэвдэг, барилга угсралтын үйл ажиллагаа эсвэл үерийн хяналтын арга хэмжээнд нөлөөлж болзошгүй цаг уурын эрсдэлийн талаарх мэдээлэл.

Усны чанар ба хүртээмж

Гадаргын болон газрын доорх усны чанарыг химийн болон физик шинж чанараар нь үнэлж, булингаршил, pH, ууссан хүчилтөрөгч, хүнд металл болон бусад бохирдуулагч бодисуудыг тодорхойлно. Голуудын бохирдлын түвшин өндөр байгаа тул голын ёроолын хурдасны бохирдлыг зөвшөөрөгдсөн нөлөөллийн боломжит түвшин (TEL) болон нөлөөллийн босго түвшинг (PEL) тодорхойлно. Энэхүү өгөгдөл нь төсөл хэрэгжих бүс нутгийн байгаль орчны өнөөгийн төлөв байдал болон төслийн хүрээнд төлөвлөж буй үерийн хамгаалалтын барилга байгууламжуудтай холбоотой арга хэмжээнүүдийн усны нөөцөд үзүүлэх нөлөөг тодорхойлоход тусална.

- **Гадаргын усны чанарыг хэмжих**: Шинжилгээний дээжийг голын урсгалын эх, төгсгөл болон төслийн талбайн гол цэгүүдээс цуглуулж, өөрчлөлтүүдийг бүртгэн авах бөгөөд булингаршил, pH, ууссан хүчилтөрөгч, хүнд металл, бохирдуулагч зэрэг химийн болон физик шинж чанарыг тогтооно.
- **Газрын доорх усны чанарыг хэмжих**: Урсцын тохируулгатай усан сан байгуулахтай холбоотой эсвэл гидрологийн өөрчлөлтийн нөлөөллийг үнэлэхийн тулд ойролцоох бүс нутгийн газрын доорх усны чанарыг хянана. (Өгөгдлийг төсөл

[2] *Эмзэг хүлээн авагчдад эмнэлэг, бага, дунд сургууль, шашны болон соёлын өвийн дурсгалт газрууд, сүм хийд, суурьшлын бүс, ялангуяа эмзэг бүлгийн хүн ам, усны эх үүсвэр (худаг, рашаан) гэх мэт орно.*

хэрэгжих талбайн ойролцоох газрын доорх усны хяналтын худагнуудаас авах шаардлагатай.)

- **Голын ёроолын хурдас бохирдлыг хэмжих**: Голын ёроолын хурдас дах хүнд металл болон органик бохирдуулагч зэрэг бохирдуулагч бодисуудад төвлөрнө.

Агаарын чанар

Төслийн талбай болон төлөвлөж буй байршлуудын трассын дагуу тоосонцор (PM10, PM2.5), азотын давхар исэл (NO2) болон бусад бохирдуулагчид хэмжилт хийнэ. Барилгын үйл ажиллагаанаас үүдэлтэй тоосжилт, бохирдол, ялангуяа орон сууцны хороолол эсвэл байгаль орчин, нийгмийн эмзэг бүсүүдийн ойролцоо хэсгүүдэд төвлөрөх шаардлагатай. Хэмжилтийн мэдээлэл нь барилгын үе шатанд тоосжилтыг хянах, агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг төлөвлөхөд ач холбогдолтой.

Дуу шуугианы түвшин

Төслийн талбай орчмын суурьшлын бүсүүдийн орчны дуу чимээний түвшинг хэмжинэ. Барилгын үйл ажиллагаанаас шалтгаалан дуу чимээн, шуугианы бохирдол нэмэгдэж болзошгүй тул олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдалд үзүүлэх нөлөөллийг уг БОННҮ-ээр тодорхойлно. Дуу чимээг бохирдлыг бууруулах, хянах арга хэмжээг барилгын үе шатанд хэрэгжүүлэхэд энэхүү дуу чимээний хэмжилтийн өгөгдөл чухал үүрэгтэй.

Ургамалжилт ба амьтны аймаг

Хэдийгээр төсөл хэрэгжүүлэх бүс нутаг нь хотжилтын нөлөөгөөр орчны бохирдолд ихээр өртсөн боловч голын эрэг орчмын ургамал болон үлдсэн амьтны аймаг нь орон нутгийн экосистемд хувь нэмрээ оруулсаар байна. Голын эргийг тогтворжуулах, хөрсний элэгдлээс урьдчилан сэргийлэх, орон нутгийн биологийн олон янз байдалд үзүүлэх нөлөөг ойлгоход ургамалжилт ба амьтны аймгийн судалгаа чухал ач холбогдолтой. Хэдийгээр хот орчмын усны бохирдлоос шалтгаалж биологийн олон янз байдлын төлөв харьцангуй алдагдсан ч дараах судалгааг хийх шаардлагатай.

- Ургамлан нөмрөгийн төлөв байдлын судалгаа: Голын эрэг (эрэг орчмын бүс) дагуух ургамлан нөмрөг, ургамлын төрөл зүйлийг үнэлж, төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, түүний ойр орчинд ховор, нэн ховор ургамлын төрөл зүйл болон харь зүйлийн ургамал байгаа эсэхийг тодорхойлно. Түүнчлэн хөрсний тогтвортой байдал, элэгдлээс урьдчилан сэргийлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг ургамлын төрөл зүйлүүдэд анхаарлаа хандуулна. Төсөл хэрэгжих бүс нутгууд, голын эрэг орчмын газруудын ургамалжилтын нормчлогдсон ялгаврын индекс (NDVI)-ийг тодорхойлно.
- Амьтны аймгийн судалгаа: Жижиг сээр нуруугүйтэн, хуурай газрын амьтад, шувуу, загас болон голын ёроолын амьтдыг судална. Хэдийгээр голын усны биологийн олон янз байдал бохирдлоос шалтгаалж харьцангуй доройтсон ч, энэхүү үнэлгээгээр жижиг зүйлүүдийн экологийн үүрэг болон ялангуяа голын эргийн бүс орчимд байж болзошгүй хамгаалагдсан зүйлүүдийг тодорхойлж болзошгүй юм.

4.4. Нийгмийн суурь мэдээлэл цуглуулах

Зөвлөх нь зөвлөх компани нь төслийн нөлөөлөлд өртөж болзошгүй харьяа хороодын нийгэм-эдийн засгийн одоогийн нөхцөл байдал, соёлын онцлог, эмзэг байдлыг тодорхойлсон иж бүрэн нийгмийн суурь мэдээллийг цуглуулах үүрэгтэй. Энэхүү мэдээлэл нь төслийн нийгмийн нөлөөллийг үнэлж, тохиромжтой бууруулах арга хэмжээг боловсруулах суурь болно.

Хүн ам зүйн мэдээлэл

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн хүн амын ерөнхий мэдээлэл, хүн амын тархалт, онцлог хэв шинжийг тодорхойлох.

- Хүн амын тоо: Төслийн нөлөөлөлд өртөж болзошгүй бүсийн нийт хүн амын тоо, тархалтын мэдээллийг дүүрэг болон хороодоор (жишээ нь, Баянзүрх, Сүхбаатар, Сонгинохайрхан, Хан-Уул) гаргах.
- Насны бүтэц: Хүн амын тоог насны бүлгээр (жишээ нь: хүүхэд, хөдөлмөрийн насны, өндөр настан) ангилна.
- Хүйсийн мэдээлэл: Хүйсийн харьцаа, хүйсийн ялгаа, жендертэй холбоотой асуудлыг тодорхойлох.
- Өрхийн хэмжээ ба бүтэц: Өрхийн ам бүлийн дундаж тоо, өрхийн тоо, гэр бүлийн бүтэц
- Төслийн нөлөөлөлд өртсөн иргэд: Шууд болон шууд бус байдлаар төслийн нөлөөлөлд өртөх хүмүүсийг тодорхойлох.
- Үндэстний цөөнх: Төслийн нутаг дэвсгэрт байгаа угсаатны бүрэлдэхүүн, уугуул болон үндэстний цөөнхийн талаарх мэдээлэл. Нийгмийн суурь мэдээлэл цуглуулах явцад Дэлхийн Банкны БОНС7-ийн шаардлагын дагуу нутгийн угуул иргэд болон үндэстний цөөнх байгаа эсэхийг тодорхойлдог.Үүнд нутгийн иргэдийн нийгэм, соёл, эдийн засгийн онцлогийг нарийвчлан судалж, газар ашиглалт, амьжиргаа, уламжлалт зан үйлийг харгалзана. Аливаа үндэстний цөөнхийг зөв тодорхойлж, төслийн төлөвлөлтөд тэдний эрхийг хүндэтгэхийн тулд орон нутгийн иргэд, оролцогч талуудтай хамтран ажиллах, тэр дундаа хорооны засаг захиргааны байгууллага, ТББ, уугуул иргэдийн байгууллагуудтай зөвлөлдөх шаардлагатай.

Нийгэм-эдийн засгийн байдал

Төсөл хэрэгжих бүс нутгийн иргэдийн орлого, амьжиргаа, үйлчилгээний хүртээмжид анхаарлаа хандуулж, нийгэм, эдийн засгийн нөхцөлийг үнэлнэ.

- Орлогын түвшин: Өрхийн дундаж орлого ба орлогын эх үүсвэр.
- Хөдөлмөр эрхлэлтийн түвшин: Хөдөлмөр эрхлэлтийн байдал, салбарууд
- Амьжиргаа: Орон нутгийн иргэдийн гол амьжиргаа, эдийн засгийн үйл ажиллагаа (жишээ нь, газар тариалан, мал аж ахуй, жижиг дунд бизнес, албан бус хөдөлмөр г.м).
- Ядуурлын түвшин: Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур буюу эдийн засгийн хүндрэлтэй тулгарсан хүмүүсийг оролцуулан зорилтот бүлгийн хүн амыг тодорхойлох.
- Нийгмийн нэн чухал үйлчилгээ авах хүртээмж:
    - Ус: Ахуйн хэрэглээний цэвэр усны хүртээмж.
    - Боловсрол: Сургуулийн хүртээмж, боловсролын түвшин.
    - Эрүүл мэндийн үйлчилгээ: Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, хамгийн ойрын эмнэлэг, эмнэлэг хүртэлх зай, эрүүл мэндийн үйлчилгээ авах боломж.

Газар эзэмших, өмчлөх эрх

БОНС5-ын (Газар чөлөөлөх, газар ашиглах хязгаарлалт, албадан нүүлгэн шилжүүлэх) дагуу төслийн бүс дэх газар өмчлөл, газар ашиглалтыг тодорхойлох. Зөвлөх нь дараах байршлуудын нүүлгэн шилжүүлэх, эсвэл газар чөлөөлөлтөд өртөж болзошгүй айл өрх, иргэдийн тоог тодорхойлно:

Онцгой хамгаалалтын бүсэд оршин сууж буй өрхүүдийн кадастрын мэдээлэл болон нэгж талбарын мэдээллийг ашиглан зураглал хийж, нөлөөлөлд өртөж болзошгүй иргэдийг нарийвчлан тодорхойлох шаардлагатай.

Эмзэг өртөмтгий, зорилтот бүлгүүд

Хөдөө орон нутгаас шилжин ирэгсэд, газрын зөвшөөрөлгүй айл өрх, өндөр настан, өрх толгойлсон эцэг эхчүүд, амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэд, ажилгүйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдний асран хамгаалагчид зэрэг төслийн

хүрээнд харьцангуй тэгш бус, хүнд өртөж болзошгүй тодорхой хүн амын бүлгүүдийн эмзэг байдлыг тодорхойлж, үнэлнэ.

Соёлын өв
Төслийн хүрээнд болон эргэн тойронд археологи, түүх, соёлын ач холбогдол бүхий дурсгалт газруудыг тодорхойлох, үнэлэхийн тулд соёлын өвийн судалгааг хийх. Дэлхийн Банкны БОНС8 болон Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллаж, соёлын үнэт зүйлсийг хамгаалах, эрсдэлийг бууруулах зорилгоор "Санамсаргүй олдвор" журмыг боловсруулж, хэрэгжүүлэх.

4.5. Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ

БОННҮ-д төслийн нөлөөллийн бүс дэх физик, биологийн болон нийгэм-эдийн засгийн шууд ба шууд бус, хуримтлагдсан нөлөөллийг барилга угсралтын өмнөх үе шат, барилгын ажил гүйцэтгэх үе шат, үерийн хамгаалалтын барилга байгууламж ашиглах үеийн үйл ажиллагааны үе шат тус бүрээр үнэлнэ.

Барилгын ажил гүйцэтгэхийн өмнөх үе шат:

- Газар чөлөөлөлттэй холбоотой болзошгүй нөлөөллийг үнэлж, Нүүлгэн шилжүүлэлтийн бодлогын баримт бичгийг (НШББББ) бэлтгэх.
- Эргийн хамгаалалттай бүсүүд, соёлын өвийн дурсгалт газар, байгаль экологийн хувьд эмзэг бүсүүдийг тогтоож, нөлөөллөөс зайлсхийх болон бууруулах арга хэмжээг санал болгох.
- Экосистемийн үйлчилгээ, биологийн олон янз байдал, тэр дундаа амьдрах орчныг хадгалах, хамгаалах арга хэмжээг боловсруулах.

Барилгын ажил гүйцэтгэх үе шат:

- Ургамлан нөмрөгийн талхагдал, байгалийн амьдрах орчинд үзүүлэх нөлөөллийг үнэлэх.
- Барилгын ажлын явцад хөрсний эвдрэл, тунадасжилт, гадаргын усны чанарт үзүүлэх нөлөөллийн эрсдэлүүдийг үнэлэх.
- Хурдас, лаг хуримтлал, аюултай хог хаягдал зэрэг барилга байгууламжаас үүсэж болзошгүй хог хаягдлын нөлөөллийг үнэлж, бууруулах арга хэмжээ боловсруулах.
- Барилгын ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйтай холбоотой эрсдэлүүдийг тодорхойлж, бууруулах арга хэмжээ санал болгох. Үүнд хүнд машин механизм ашиглах, аюултай материалтай харьцах, барилгын ажлын үеэр үүсэж болзошгүй ослын эрсдэлүүдийг хамааруулна. Мөн удаан хугацаанд дуу чимээ, доргионд өртөх болон бусад барилгын ажлаас үүдэлтэй эрсдэл, болзошгүй сөрөг нөлөөллийг багтаана.
- Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд үзүүлэх нөлөөллийг үнэлэх, үүнд шуугиан, агаарт дэгдэх тоос, замын хөдөлгөөнөөс үүдэлтэй сөрөг нөлөөллийг авч үзэх. Нийгмийн нөлөөллийн хувьд эмзэг, өртөмтгий газрууд, тухайлбал сургууль, эмнэлэг болон төсөл хэрэгжих газартай ойролцоо орших орон сууцны бүсэд онцгой анхаарал хандуулж, тэдгээрийн эмзэг, өртөмтгий байдлыг зохих ёсоор үнэлэх.
- Орон нутгийн иргэдэд үзүүлэх түр зуурын нөлөөлөл, тухайлбал, гэрт нэвтрэх эрхийг хязгаарлах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор ТЗХМТ-г боловсруулах.

Үерийн хамгаалалтын барилга байгууламж ашиглах үеийн үйл ажиллагааны үе шат:

- Бохир усны дэд бүтцийн урт хугацааны нөлөөллийг үнэлэх, ялангуяа эргэн тойрны экосистемд, усны нөөцийн динамик болон эдгээр байгууламжийн ойролцоох хөрсний тогтвортой байдалд үзүүлэх нөлөөг судлах.
- Шугам хоолой ашиглалтаас үүдэлтэй эрсдэлүүдийг үнэлэх. Үүнд хоолой хагарах, алдагдах магадлал болон хөрс, ус, ойролцоох орон нутгийн иргэдэд үзүүлэх нөлөөллийг судалж, байгаль орчин, эрүүл мэндийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөх.

- Үерийн хамгаалалтын суваг, урсцын тохируулгатай ус хуримтлуулах сан, бохир усны шугам хоолойн ашиглалт, засвар үйлчилгээнд оролцож буй ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдалд учирч болзошгүй эрсдэлийг үнэлэх. Үүнд хаалттай орчинд ажиллах, аюултай материалтай харьцах, тогтмол засвар үйлчилгээтэй холбоотой эрсдэлүүдийг хамруулна.

Хуримтлагдсан нөлөөлөл

- Одоо хэрэгжиж буй болон төлөвлөгдсөн дэд бүтцийн төслүүд (жишээ нь, бохир ус цэвэрлэх байгууламжууд, усан сангууд, хот байгуулалтын төслүүд болон авто замын сүлжээнүүд) болох хуримтлагдах нөлөөллийн эх үүсвэрүүд нь төсөлтэй хэрхэн хуримтлагдах нөлөөлөл үүсгэхийг тодорхойлж, үнэлэх.
- Нөлөөллийн бүсүүдийн давхцал бүхий талбайнуудыг тодорхойлох, хамтран ашиглагдах нөөцүүд (жишээ нь, ус, газар) болон нийтлэг байгаль орчин, нийгмийн эрсдэлүүдэд анхаарах.

.

Гидрологийн нөлөөллийн шинжилгээ

БОННҮ-ийн хүрээнд гидрологийн загварчлал хийхгүй. Үүний оронд ТЭЗҮ-д багтсан гидрологийн өгөгдөл болон үерийн эрсдэлийн загварчлалд тулгуурлана. БОННҮ нь ТЭЗҮ-ийн гидрологийн шинжилгээнд тодорхойлсон голын морфологийн өөрчлөлт, газрын доорх усны сэлбэлт, усны хүртээмж, хурдас зөөвөрлөлтөөс үүдэлтэй байгаль орчин, нийгмийн нөлөөллийг үнэлнэ.

Хувилбарын шинжилгээ

БОННҮ-ний хүрээнд төслийн загвар, байршил, технологийн хувьд болон үерийн хамгаалалтын барилга байгууламж байхгүй буюу "төсөл хэрэгжихгүй байх" үеийн байгаль орчин, нийгмийн нөлөөллийг тодорхойлж, харьцуулсан хувилбарын шинжилгээ хийнэ.

Гол зорилтууд

1. "Төсөл хэрэгжихгүй байх" хувилбарыг төслийн бусад боломжит хувилбаруудтай байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийн хувьд системтэйгээр харьцуулах.
2. Техникийн, байгаль орчны болон нийгмийн хэмжигдэхүүнүүдийг харгалзан хувилбар бүрийн нөлөөллийг бууруулах боломжийг үнэлэх.
3. Боломжтой тохиолдолд, алтернатив хувилбаруудын эдийн засгийн талыг, үүнд хөрөнгө оруулалтын болон үйл ажиллагааны зардал, тухайн бүс нутагт тохирох эсэх, цаашлаад хувилбаруудын урт хугацааны тогтвортой байдлыг үнэлэх.[3]
4. Техникийн болон санхүүгийн хүчин зүйлээс шалтгаалсан шийдвэр гаргалтад байгаль орчин, нийгмийн хүчин зүйлсийг хамааруулан нэгтгэх.

Төслийн дизайн ба байршил

Үерийн хамгаалалтын байгууламжийн (далан, шуудуу, суваг, ус зайлуулах систем болон холбогдох усны барилга байгууламж) загвар, байршлын хувилбаруудыг үнэлэх. Үнэлгээнд дараах зүйлсийг харгалзана.

- Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн эрсдэл, боломжтой тохиолдолд нөхөн төлбөрийн зардлыг тооцох.
- Хамгаалалттай бүс, усны эх үүсвэр гэх мэт байгаль орчин, нийгмийн эмзэг хүлээн авагчдад ойр байх эрсдэл.
- Бага нөлөөлөл бүхий загвар, байршлыг сонгож, нөлөөллийг багасгах боломжууд.

Технологийн сонголт

Төслийн бүрэлдэхүүн хэсгүүдийн хувьд боломжит барилгын технологийг (жишээ нь, дэд бүтцийн шугам хоолойг уламжлалт аргаар ухаж солих болон шуудуугүй технологийн харьцуулалт) үнэлэх. Эдгээрийг дараах шалгуурын дагуу харьцуулна:

---

[3] *Уг заалтыг ТЭЗҮ боловсруулах багтай зөвшилцөх шаардлагатай.*

- Байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, үүнд хөрсний эвдрэл, дуу чимээ, агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл.
- Нийгмийн нөлөөлөл, үүнд түр хугацаанд газар ашиглалт, төслийн ойролцоох бүсийн иргэдэд үзүүлэх нөлөө.
- Орон нутгийн нөхцөлд тохирсон эдийн засгийн үр ашиг болон техникийн боломж

Үйл ажиллагааны хувилбарууд

Төслийн гол бүрэлдэхүүн хэсгүүдийн байгаль орчин, нийгмийн урт хугацааны эрсдэл, сөрөг нөлөөллийг багасгах зорилгоор төслийн гол бүрэлдэхүүн хэсгүүдийн үйл ажиллагааны ялгаатай арга барилуудыг тодорхойлох. Үүнд:

- Усны чанар, тоо хэмжээг байгаль орчинд ээлтэй, тогтвортой байлгах үүднээс цэвэрлэх байгууламж, усан сан, ус шахах станцуудын үйл ажиллагааны стратегийг харьцуулах.
- Олон нийтийн аюулгүй байдалтай холбоотой эрсдэлийг бууруулах зорилгоор үерийн хамгаалалтын байгууламжийн засвар үйлчилгээний бусад арга замуудыг судлах.

"Төсөл хэрэгжихгүй байх" хувилбар

Төслийг хэрэгжүүлэхгүй тохиолдолд байгаль орчин, нийгэм, эдийн засгийн ямар үр дагавар гарахыг тодорхойлно. Үерийн эмзэг байдал нэмэгдэх, байгаль орчны доройтолд нэрвэгдэх, аливаа арга хэмжээ аваагүйн улмаас учирч болзошгүй нийгэм эдийн засгийн хохирол зэрэг болзошгүй эрсдэлийг онцлон тайлбарлана.

ТЭЗҮ-ийн багтай хамтран ажиллах

Зөвлөхийн баг нь ТЭЗҮ-ийн багтай нягт хамтран ажиллаж, хувилбарын шинжилгээний нийцлийг баталгаажуулна. ТЭЗҮ-ийн баг нь хувилбаруудын урьдчилсан зураг төсөл, маршрут, зардлын тооцоог гаргаж өгөх ёстой бол БОННҮ-ний баг эдгээр хувилбаруудыг байгаль орчин, нийгмийн эрсдэл, ялангуяа газар чөлөөлөх нөлөөллийн хувьд үнэлнэ. Баг хоорондын хамтын ажиллагаа, уялдаа холбоог хангаснаар техник, эдийн засгийн үндэслэл болон байгаль орчин/нийгмийн хүчин зүйлсийг нэгтгэсэн хамгийн тохиромжит хувилбарыг сонгох боломжтой.

Хүлээгдэж буй үр дүн

БОННҮ-ийн Хувилбарын шинжилгээний бүлэг нь харьцуулалт хийсэн хувилбаруудын иж бүрэн, нотолгоонд суурилсан мэдээллийг багтаана. Үүнд

- Хувилбар бүрийн байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийн тоон болон чанарын үнэлгээ.
- Боломжтой тохиолдолд эдийн засгийн үнэлгээ, зардал-үр ашгийн шинжилгээг багтаах.
- Хувилбаруудын харьцуулалтыг тодорхой харуулсан зураг
- Сонгосон хувилбарын тодорхой үндэслэл

4.6. Нөлөөллийг бууруулах арга хэмжээ ба менежментийн төлөвлөгөө

Зөвлөх нь БОННҮ-ний хүрээнд тодорхойлсон байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллүүдийг үр дүнтэй шийдвэрлэх зорилгоор нөлөөллийг бууруулах шаталсан аргачлалын (зайлсхийх, багасгах, бууруулах, нөхөн сэргээх) дагуу бууруулах арга хэмжээг тодорхойлно. Энэ бүлэг дараах бүрэлдэхүүн хэсгүүдийг хамруулах ба зөвхөн доорх жагсаалтаар хязгаарлагдахгүй.[4]

[4] *БОНМТ-г боловсруулахад дээрх дурдсан шаардлагуудаас гадна "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө хянан батлах, тайлагнах журам"ыг харгалзах шаардлагатай.*

- Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө (БОНМТ): Төсөл хэрэгжих талбайн байршил, газарзүйн онцлогт тохирсон нөлөөллийг бууруулах арга хэмжээг багтаасан байх ёстой. Үүнд:
    - Нөлөөллийг бууруулах арга хэмжээ: Байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн тодорхой арга хэмжээнүүдийг шаталсан аргачлалын дагуу ангилах (зайлсхийх, багасгах, багасгах, нөхөн сэргээх).
    - Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны үлгэрчилсэн дүрэм (БОНҮАҮД): Төслийн барилга угсралт болон үйл ажиллагааны үеийн байгаль орчин, нийгмийн нөлөөллийг зохицуулах удирдамж.
    - Хяналтын протоколууд: Нөлөөллийг бууруулах арга хэмжээний үр дүнг үнэлэх үзүүлэлт, аргачлал, дээж авах байршил, хуваарь зэрэг нарийвчилсан хяналтын тогтолцоо.
    - Институцийн зохицуулалт: БОНУТ-г хэрэгжүүлэх, хяналт тавих үүрэг бүхий байгууллага, хувь хүмүүсийн тодорхой хариуцлага.
    - Чадавх бэхжүүлэх: Төслийн оролцогч талууд болон хариуцсан этгээдүүд БОНМТ-г үр дүнтэй хэрэгжүүлэх мэдлэг, ур чадвар эзэмших сургалт, чадавхыг бэхжүүлэх арга хэмжээ.
    - Хэрэгжилтийн хуваарь: Төслийн бусад үйл ажиллагаатай уялдсан нөлөөллийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх хуваарь.
    - Зардлын тооцоо: Нөлөөллийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалтын болон үйл ажиллагааны зардлын тооцоо.
    - Гүйцэтгэлийн үзүүлэлтүүд: Нөлөөллийг бууруулах арга хэмжээний үр нөлөөг хянах хэмжигдэхүйц үзүүлэлтүүд.

- Мониторингийн төлөвлөгөө: Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг БОНМТ-ний бүрдэл болгон боловсруулах ба үүнд:
    - Хэмжих үзүүлэлтүүд: Байгаль орчин, нийгмийн үзүүлэлтүүд.
    - Дээжлэлт авах аргачлал ба цэгүүд: Төслийн талбайн дагуух дээж авах цэгүүдийн байршил болон ашиглах аргачлал.
    - Мониторингийн давтамж: Төслийн хэрэгжилтийн үе шатуудад байнгын мониторинг хийх интервалуудыг тодорхойлох.
    - Үндэсний стандартууд: Хяналт шинжилгээтэй холбоотой баримтлах стандартуудыг нарийвчлан тодорхойлох.
    - Залруулах арга хэмжээний босго: Хүлцэх хэмжээг давсан тохиолдолд нөлөөллийг бууруулах арга хэмжээ болон үйл ажиллагаанд өөрчлөлт хийхийг шаардсан тодорхой босго хэмжээнүүдийг тодорхойлох.

4.7. Оролцогч талуудын оролцоо ба мэдээллийг олон нийтэд түгээх

Зөвлөх нь төсөлд шууд болон шууд бусаар өртөж буй бүх оролцогч талуудыг тодорхойлж, тэдний сонирхлын түвшин, нөлөөлөл, эмзэг байдлын түвшний дагуу ангилах үүрэгтэй. Зөвлөх нь тэдний санал, зөвлөмж төслийн хэрэгжилтийн явцад зохистой байдлаар шийдвэрлэх чиглэлээр талуудын оролцоог хангахдаа эмзэг, өртөмтгий зорилтот хүн амын бүлэгт онцгой анхаарал хандуулах шаардлагатай.
Зөвлөх нь орон нутгийн иргэд, төслийн талбайн гэр хорооллын оршин суугчид, хороодын Засаг дарга нар, төрийн гол байгууллагууд, эмзэг, өртөмтгий бүлэг, үндэстний цөөнх зэрэг оролцогч талуудыг төслийн үйл ажиллагаанд татан оролцуулах стратегийг нарийвчлан тодорхойлсон Оролцогч талуудын оролцоог хангах төлөвлөгөөг (ОТОХТ) бэлтгэх ёстой. Цаашлаад, Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээг (БОННҮ) боловсруулах явцад оролцогч талуудтай зөвлөлдөх уулзалт, хэлэлцүүлэг өрнүүлж, төслийн талаарх тэдний санал, хандлагыг тодорхойлно.
Төслийн талаарх оролцогч талуудын бодол, саналыг тодруулах зорилгоор гол мэдээлэгчийн ярилцлага, фокус бүлгийн хэлэлцүүлэг, олон нийтийн зөвлөлдөх уулзалт зэрэг олон төрлийн оролцооны аргыг ашиглаж болно. Төсөл хэрэгжих бүс нутгийн хорооны засаг дарга нартай харилцах нь маш чухал бөгөөд тухайн орон нутгийн түвшинд

хэлэлцүүлэг хийхэд дэмжлэг үзүүлж, орон нутгийн иргэдийг төлөөлүүлэх, хэлэлцүүлгийг саадгүй зохион байгуулах боломжийг бүрдүүлдэг.
Түүнчлэн зөвлөх компани нь төслийн үйл ажиллагаа үндэсний болон орон нутгийн бодлого, дүрэм журамтай нийцүүлэх зорилгоор голлох төрийн байгууллагуудын саналыг харгалзан үзнэ. Хэлэлцүүлгээс гарсан дүгнэлт, оролцогч талуудын санаа зовнил, хүлээлтийг тодорхойлсон бүх мэдээллийг оролцогч талуудын хүлээн авах боломжтой хэлбэр, хэлээр нийтэлж, нийтэд ил тод болгоно.

4.8. Гомдол барагдуулах механизм (ГБМ)

Зөвлөх нь соёлын хэм хэмжээний хувьд зохистой, аюулгүй, хүртээмжтэй байдлаар оролцогч талуудын санал, гомдлыг, түүн дотор нэргүй гомдлыг хүлээн авч үр дүнтэй, ил тод байдлаар шийдвэрлэх ГБМ-ыг боловсруулах үүрэгтэй. Энэхүү ГБМ-ыг боловсруулахдаа байгууллагын чадавхыг бэхжүүлэх замаар төслийн үйл ажиллагаатай холбоотой санал, гомдол барагдуулах үйл явцын урт хугацааны тогтвортой байдлыг хангах үүднээс төрийн засаг захиргааны байгууллагуудын одоогоор ашиглаж буй гомдол барагдуулах тогтолцоотой нэгтгэж, уялдуулахыг эрмэлзэх ёстой.

ГБМ нь дараах шаардлагуудыг хангах ёстой:

- Санал гомдлыг ил тод, шударга, соёлын хувьд мэдрэмжтэй байдлаар хурдан хүлээн авч, шийдвэрлэх.
- Гомдол, саналын мэдээллийг тасралтгүй хянах, баримтжуулах системийг бий болгож, оролцогч талуудад гомдлын явц болон шийдвэрлэлтийн үр дүнгийн талаар тогтмол мэдээлэх зохицуулалтыг батгаасан байх.
- Оролцогч талуудад авсан арга хэмжээ болон шийдвэрлэлтийн үр дүнг цаг тухайд нь мэдээлэх тодорхой санал хүсэлтийн эргэх холбоог (feedback loop)-г багтаах.
- Ялангуяа эмзэг, өртөмтгий болон оролцооны хувьд хязгаарлагдмал зорилтот бүлгүүдийн хэл, бичиг үсэг, хүйс, хөгжлийн бэрхшээлтэй холбоотой саад бэрхшээлийг онцгойлон анхаарч төслийн бүх оролцогч талуудад нээлттэй, хүртээмжтэй байх.
- Гомдлыг хөндлөнгийн, шударга байдлаар шийдвэрлэх, шаардлагатай тохиолдолд гомдол санал дахин давтагдахаас сэргийлэх арга хэмжээг багтаах.

Түүнчлэн зөвлөх нь ГБМ-ыг төслийн үйл ажиллагааны бүхий л үе шаттай уялдуулах үүрэгтэй. Тухайлбал, төслийн нөлөөлөлд өртсөн иргэд болон оролцогч талуудтай итгэлцэл бий болгох зорилгоор энэхүү ГБМ-ын талаарх мэдээллийг орон нутгийн иргэдтэй зөвлөлдөх уулзалт хийх болон талуудын оролцоог хангах арга хэмжээнүүдэд идэвхтэй таниулан сурталчлах ёстой. Ингэснээр төслийн оролцогч талууд төсөл хэрэгжих бүхий л хугацааны туршид ГБМ-г хэрхэн ашиглах талаар сайн мэдээлэлтэй болно.

4.9. Байгалийн болон чухал амьдрах орчныг хамгаалахтай холбоотой шаардлага

Зөвлөх нь төслийн үйл ажиллагаа чухал амьдрах орчинд сөрөг нөлөө үзүүлэх эсэхийг үнэлж, баталгаажуулна. Байгалийн амьдрах орчны хувьд, зохих арга хэмжээ авахгүйгээр тухайн орчныг их хэмжээгээр өөрчлөх эсвэл доройтуулах нөхцөл үүсэхгүй байхыг баталгаажуулах шаардлагатай. Мөн хууль ёсны хамгаалалттай бүс нутгуудад болон бусад бүс нутагт хамгааллын үр дүнг нэмэгдүүлэх зөвлөмжийг үнэлгээнд тусгах ёстой[5].

5. Зөвлөхийн хүлээлгэн өгөх баримт бичгийн жагсаалт

Зөвлөх нь Дэлхийн банкны санал зөвлөмжийг тусгаж, захиалагч талд дараах баримт бичгүүдийг хүргүүлнэ. Хүлээлгэж өгөх бүх баримт бичиг Монгол болон Англи хэлээр бэлтгэгдсэн байх шаардлагатай. Хүлээлгэн өгөх баримт бичгийн жишиг загварыг тус ажлын даалгаврын хавсралтад тусгасан болно.

---

[5] *Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хамаатуулж болно.*

Байгаль орчны төлөв байдлын тайлан: Байгаль орчны төлөв байдлын тайланг Монгол улсын дотоодын холбогдох хууль, журмын дагуу боловсруулна.[6]

Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний (БОННҮ) тайлан: Монголын Улсын холбогдох хууль, тогтоомж, журам болон Дэлхийн банкны Байгаль орчин, нийгмийн стандарт (БОНС1-10)-ын шаардлагад нийцүүлэн боловсруулсан баримт бичиг. Хуримтлагдах нөлөөлөл, хувилбарын шинжилгээ, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний стратеги зэргийг багтаасан байгаль орчин, нийгмийн болзошгүй нөлөөллийг үнэлдэг цогц тайлан.

Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө (БОНМТ)[7]: Үнэлгээний явцад илэрсэн байгаль орчин, нийгмийн эрсдэлийг шийдвэрлэх бие даасан төлөвлөгөө. Төлөвлөгөөнд тодорхой арга хэмжээнүүд, хяналтын төлөвлөгөө, хариуцах байгууллага, хугацаа, сөрөг нөлөөллийг үр дүнтэй бууруулах, хяналт-мониторинг хийхэд шаардагдах нөөцүүдийг тодорхойлон тусгана. Хавсралтууд нь дараах зүйлсийг багтаана:

- Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны үлгэрчилсэн дүрэм (БОНҮАҮД): Тодорхой байршилд үерийн далан барих, бохирын системийг шинэчлэх явцад дуу чимээ, тоосжилт, хог хаягдал, усны бохирдол зэрэг барилга байгууламжтай холбоотой байгаль орчинд үзүүлэх ерөнхий нөлөөллийг зохицуулах удирдамжийг агуулсан байх ёстой.
- Түр замын хөдөлгөөний менежментийн төлөвлөгөө (ТЗХМТ): Үерийн суваг, шуудуу, далан барих, бохир усны дэд бүтцийг шинэчлэх явцад үүсэж болзошгүй замын хөдөлгөөний саатлыг багасгах, явган зорчигч, тээврийн хэрэгслийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ, үүнд барилга байгууламжийн улмаас зам, гарц хааж болзошгүй тохиолдолд айл өрхийн нэвтрэх түр зохицуулалтыг тусгах шаардлагатай.

Байгаль орчин, нийгмийн зорилтын төлөвлөгөөний төсөл (БОНЗТ)[8]: Хууль эрх зүйн хүрээнд заавал биелүүлэх шаардлагатай, байгаль орчин болон нийгмийн эрсдэл, нөлөөллийг шийдвэрлэх тодорхой арга хэмжээ, үйл ажиллагаа, хугацааг тусгасан баримт бичиг. Энэхүү төлөвлөгөөнд Дэлхийн Банкны загварын дагуу БОННҮ, БОМТ, НШБББ, ХУЖ, ОТОХТ-г хэрэгжүүлэхтэй холбоотой Зээлдэгчийн үүрэг амлалтыг нарийвчлан тусгах ёстой. Түүнчлэн хяналт-шинжилгээ, үнэлгээ чадавх бэхжүүлэх, ГБМ-ийн үйл ажиллагаатай холбоотой арга хэмжээнүүдийг багтаана. БОНЗТ нь Монгол Улсын дүрэм журам болон ДБ-ны БОНС-той нийцэж, зээлдэгч, санхүүжүүлэгч болон бусад оролцогч талуудтай зөвшилцсөний үндсэн дээр боловсруулагдах ёстой.

Хөдөлмөрийн удирдлагын журам (ХУЖ): Бохир усны шугам хоолойг шуудуу ухалгүйгээр доторлох ажилд оролцох ажилчдын хөдөлмөрийн нөхцөл, шударга, эрх тэгш байдал, ХАБЭА-ын эрсдэлүүдийг шийдвэрлэх арга хэмжээ, ажилчдын өргөдөл, гомдлыг шийдвэрлэх механизмыг тусгасан баримт бичиг.

Нүүлгэн шилжүүлэлтийн бодлогын баримт бичиг (НШБББ): Төслийн нөлөөлөлд өртөж болзошгүй иргэд, хүн амын бүлгийг тодорхойлох, төслийн үйл ажиллагаанаас үүдсэн эд хөрөнгө, газар, барилга байгууламжид нөхөн олговор олгохтой холбоотой зохицуулалт, нүүлгэн шилжүүлэлтийн үр дагаврыг шийдвэрлэх бодлого, журам зэргийг багтаасан бодлогын баримт бичиг. Мөн НШБББ-т Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөг (НШТ) боловсруулахад дагаж мөрдөх зарчим, аргачлалын талаар тусгах ёстой бөгөөд НШТ-г Монгол Улсын холбогдох зохицуулалт, Дэлхийн банкны БОНС5 стандартад нийцүүлэн боловсруулж, барилгын үйл ажиллагаа эхлэхээс өмнө хэрэгжүүлдэг.

Оролцогч талуудын оролцоог хангах төлөвлөгөө (ОТОХТ): БОНС10-т заасан шаардлагын дагуу төслийн амьдралын мөчлөгийн туршид оролцогч талуудтай тасралтгүй

---

6 Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлтийг гаргуулахаар энэхүү тайланг ТЭЗҮ-ийн хамт БОУАӨЯ-д хүргүүлэх юм.

7Төслийн үйл ажиллагааны нарийн төвөгтэй байдал, хүрээлэн буй орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллөөс хамааран энэ нь бие даасан баримт бичиг эсвэл БОННҮ тайлангийн нэг хэсэг байж болно. Үндэсний шаардлагын дагуу энэ нь ихэвчлэн БОННҮ-ын хэсэг болдог тул БОННҮ тайлангийн нэг хэсэг хэлбэрээр хүлээн авч болно.

8 Энэхүү баримт бичгийн төслийг хүргүүлэхэд хүлээн зөвшөөрөх үндэс болно. Эцсийн байдлаар төсөл эхлэхээс өмнө Дэлхийн банк болон Зээлдэгчийн хооронд байгуулдаг баримт бичиг тул зөвлөх үйлчилгээ үзүүлэгчид заавал эцэслэсэн төлөвлөгөө хүргүүлэх шаардлага тавихгүй. Тус тайланг баталгаажуулж, эцэслэх нь захиалагч талын үүрэг болно.

хамтран ажиллах стратегийг тусгана. ОТОХТ-д төслийн голлох оролцогч талууд, тэдэнтэй үр дүнтэй харилцах суваг, талуудын оролцоог хангах үйл ажиллагааны хэлбэрүүдийг тодорхойлж, нарийвчлан тусгасан байх ёстой.

- Зөвлөлдөх уулзалтууд, бүлгийн ярилцлага, оролцогчдын жагсаалт, хурлын тэмдэглэл зэрэг талуудын оролцооны дэлгэрэнгүй бүртгэлийг хавсаргана.

5.1. Хүлээлгэн өгөх баримт бичиг болон форматын шаардлага

Хүлээлгэн өгөх хуулбарууд :

- **Хэвлэмэл хувилбар** :
  - БОННҮ-ийн тайлангийн эцсийн хувилбар, дагалдах төлөвлөгөө, баримт бичгүүд, хавсралтуудыг 4 хувь хэвлэмэл хэлбэрээр захиалагч талд хүргүүлнэ.
- **Дижитал хувилбар** :
  - Баримт бичгийн засварлах боломжтой болон засварлах боломжгүй хэлбэрийг дижитал хэлбэрээр хүргүүлнэ.

Файлын форматууд :

1. **Засварлах боломжтой формат**: Тайлангуудыг Microsoft Word, өгөгдлүүдийг Microsoft Excel, мөн GIS-тэй холбоотой аливаа өгөгдөл нь shapefile болон бусад тохиромжтой форматтай байх.
2. **Танилцуулахад бэлэн формат**: Товч танилцуулга болон голлох үр дүн PDF болон PowerPoint форматтай, танилцуулга хэлбэрээр байх.
3. **Газарзүйн Мэдээллийн Систем (ГМС)-ийн өгөгдөл**: Газарзүйн өгөгдлийг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны ГМС-ийн системтэй нийцэх олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн форматад хүргүүлнэ.

Тайлангуудыг захиалагч талтай тохиролцсон цахим шуудангаар эсвэл үүлэн суурьтай платформоор хүргүүлэх ба хандалтын эрхийг өгнө. Бүх материалыг англи, монгол хэл дээр ирүүлнэ.

6. Ажлын даалгаврын үргэлжлэх хугацаа ба хуваарь

Тус ажлын даалгаврыг боловсруулах хугацаа зургаан сарын хугацаанд үргэлжилнэ. Энэ хугацаанд үнэлгээг бүрэн дуусгаж, холбогдох төлөвлөгөөнүүдийг боловсруулж, оролцогч талуудын оролцоо, тайлагнал зэргийг бүрэн хангаж, Дэлхийн банкны стандартууд болон Монгол улсын үндэсний дүрэм журмын аль алинд нь нийцэж байгаа эсэхийг баталгаажуулсан байх шаардлагатай. БОННҮ боловсруулах үйл ажиллагаа нь дараах үе шатуудын дагуу хэрэгжинэ.
1-р үе шат - Эхлэл (1 долоо хоног): Анхны зөвлөлдөх уулзалтууд, төслийн хамрах хүрээ, эрсдэлийн ангилал, ажлын нарийвчилсан төлөвлөгөө боловсруулах.
2-р үе шат - Үнэлгээ (14 долоо хоног): Байгаль орчин, нийгмийн суурь үнэлгээ, эрсдэлийн үнэлгээ, нөлөөллийн шинжилгээ хийх. Үүнд Байгаль орчин нийгмийн нөлөөллийн үнэлгээ (БОННҮ) болон БОНС1-10-ын шаардлагын дагуу холбогдох баримт бичиг, төлөвлөгөөнүүдийг бэлтгэх зэрэг орно.
3-р үе шат - Баримтжуулалт ба хяналт (2 долоо хоног): БОННҮ, БОНМТ болон аливаа нэмэлт баримт бичиг, төлөвлөгөөнүүдийг эцэслэн боловсруулах.
4-р үе шат – Тайлангуудыг хүлээлгэн өгөх ба олон нийтэд мэдээлэх (1 долоо хоног): Оролцогч талуудтай зөвлөлдөж, баримт бичгийг эцэслэн боловсруулж, БОНС10 болон дотоодын холбогдох шаардлагын дагуу мэдээллийг ил тод болгоно.

7. Үүрэг, хариуцлага

Захиалагчийн үүрэг хариуцлага:

- Төслийн хугацаанд зөвлөх үйлчилгээний багт шаардлагатай оффисын талбай, интернэт болон бусад логистикийн дэмжлэг үзүүлэх.

- БОННҮ-тэй холбоотой одоо байгаа баримт бичиг, суурь судалгаа, өмнөх тайлангуудад хандах боломжийг хөнгөвчлөх.
- Мэдээлэл цуглуулах, оролцогч талуудын оролцоог хангах үйл явцыг үр дүнтэй зохион байгуулах үүднээс төрийн бусад байгууллага, агентлаг, хэлтэстэй хамтран ажиллах тал дээр дэмжлэг үзүүлэх.
- Тайлангийн үр дүнг хянаж үнэлэх, шаардлагатай санал, зөвлөмжийг өгөх зорилгоор тогтмол хяналтын уулзалтуудыг зохион байгуулах.
- Зөвлөх үйлчилгээ үзүүлэгчийн тайлан, баримт бичгүүдийг тохиролцсон хугацаанд хянаж, асуулт, тодруулгад цаг тухайд нь хариу өгөх.

Тайлангуудыг баталгаажуулж, эцэслэх

БОННҮ-ний эцсийн тайлан, үүнд холбогдох бүх баримт бичгүүд, төлөвлөгөөнүүдийг (жишээ нь: БОҮАТ, БОНМТ, НШББББ, ОТОХТ, ХУЖ) УБЗАА болон Дэлхийн Банк эцсийн байдлаар хамтран баталгаажуулна.

7.1. ТЭЗҮ боловсруулах багтай хамтран ажиллах

Хамтын ажиллагааны шаардлага :
БОННҮ боловсруулах зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нь Техник эдийн засгийн үндэслэлийн (ТЭЗҮ) багтай нягт хамтран ажиллаж, төслийн дизайны техникийн, байгаль орчны болон нийгмийн асуудлуудын уялдаа холбоог хангана. Үүнд: дараах ажлууд хамаарна гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй:

1. БОННҮ болон ТЭЗҮ боловсруулах багуудын хооронд өгөгдөл, мэдээлэл үр дүнг тогтмол хуваалцах.
2. Байгаль орчин, нийгмийн үнэлгээг үерийн хамгаалалтын суваг, үерийн далан, ус зайлуулах системийн зураг төсөл, дизайны элементүүдтэй уялдуулах.
3. Газар чөлөөлөлт, биологийн олон янз байдлын менежмент, гидрологийн судалгаа зэрэг хамаарал бүхий асуудлуудыг шийдвэрлэх.
4. Төрөл бүрийн дизайн, байршил, технологи, ашиглалтын хувилбарууд болон "төсөл хэрэгжихгүй байх" хувилбарын шинжилгээнд техникийн болон техник эдийн засгийн тооцооллын хүчин зүйлсийг харгалзан, хамтран ажиллах

Хуваарьт уулзалтууд :

1. БОННҮ болон ТЭЗҮ боловсруулах багууд хуваарьт уулзалтуудыг долоо хоног бүр эсвэл хоёр долоо хоног тутам зохион байгуулж, багуудын хоорондын ажлын явц, уялдаа холбоог хэлэлцэж, ажлын давхцал, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх шаардлагатай.
2. Уулзалтын тэмдэглэлийг баримтжуулж, УБЗАА болон Дэлхийн банктай хуваалцана.

Хариуцах ажилтнуудыг томилох:
Багууд харилцаа холбоог хөнгөвчлөх, мэдээлэл солилцох, уялдаа холбоог хангах үүрэгтэй, хариуцлагатай ажилтнуудыг томилно.

7.2. Ажлын даалгаврын уян хатан байдал

Байгаль орчин, нийгмийн урьдчилан тооцоолоогүй эрсдэл үүсэх эсвэл төслийн хамрах хүрээ өөрчлөгдсөн тохиолдолд зөвлөх нь БОННҮ болон байгаль орчин, нийгмийн бусад тайлангуудыг шинэчилнэ. Үүнд:
Оролцогч талуудтай зөвлөлдөх: Шинээр үүсэж болзошгүй аливаа сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах арга хэмжээнүүд өөрчлөгдсөн тохиолдолд талуудын орол цоог хангах зорилгоор ОТОХТ-г шинэчлэх.
Төрийн байгууллагуудтай уялдаа холбоотой ажиллах: Нийслэлийн Засаг захиргаа, ДБ болон БОУАӨЯ зэрэг холбогдох эрх бүхий байгууллага, байгууллагуудын гаргасан аливаа шаардлага, удирдамжтай БОННҮ болон бусад баримт бичгүүдийг нийцүүлэх.

Ажлын даалгаврын хүлээгдэж буй үр дүнд өөрчлөлт орох: Зөвлөх нь төслийн боловсруулалтын явцад шинээр тодорхойлсон эрсдэлүүд, аливаа өөрчлөлтөөс шалтгаалан ажлын даалгаврын хүлээгдэж буй үр дүнд өөрчлөлт орсон тохиолдолд ажлын төлөвлөгөө, хуваарьт өөрчлөлт оруулж, захиалагч талын шаардлагад нийцүүлнэ.

8. Багийн бүрэлдэхүүн, мэргэшлийн шаардлага

Зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нь БОННҮ-ний зөвлөх үйлчилгээ үзүүлэх чадавхыг баталгаажуулах дараах баримт бичгүүдийг бүрдүүлнэ:

- Туршлага ба ур чадвар
    - Сүүлийн 5 жилийн хугацаанд Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННҮ) болон Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний ижил төстэй судалгаа, шинжилгээний ажил гүйцэтгэсэн байх, дангаар эсвэл бусад судалгааны байгууллагуудтай хамтран ажилласан туршлагатай байх.
    - Урьд нь хийж гүйцэтгэсэн дор хаяж 3 ижил төстэй судалгаа, шинжилгээний ажлуудын мэдээлэл, үүнд: төслийн товч тайлбар, ажлын хүрээ, захиалагчийн мэдээлэл г.м багтана.
    - Багийн гишүүдийн дэлгэрэнгүй намтар, тухайн мэргэжлийн ур чадварыг нотлох баримтууд.

Тендерт зөвхөн Монгол Улсад бүртгэлтэй, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам (БОУАӨЯ)-аас нарийвчилсан үнэлгээ хийх эрх бүхий аж ахуй нэгжүүд оролцох эрхтэй. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл нь компанийн тендерийн санал гаргах өдрөөс хойш дор хаяж 2 жилийн хугацаанд хүчинтэй байх ёстой. Зөвлөх компаниуд Монгол Улсын усны салбарт БОННҮ хийж гүйцэтгэх туршлагатай байх шаардлагатай. Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк (АХБ) болон бусад олон улсын байгууллагуудтай хамтран ажилласан туршлага нь давуу тал болно.

Энэхүү ажлын даалгаврыг гүйцэтгэх хугацаанд зөвлөх үйлчилгээ үзүүлэгчийн багт доорх мэргэжилтнүүд хамгийн багадаа багтаасан байх шаардлагатай:

Зөвлөх үйлчилгээний багийн ахлагч- Нийгмийн хамгааллын мэргэжилтэн
Ажлын туршлага/ мэргэжлийн ур чадвар

- Нийгмийн ухаан, социологи болон бусад холбогдох чиглэлээр докторын зэрэгтэй байх.
- Байгаль орчин, нийгмийн хамгааллын чиглэлээр дор хаяж 10 жилийн туршлагатай, ялангуяа нийгмийн нөлөөллийн үнэлгээ (ННҮ), нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө боловсруулалт болон оролцогч талуудтай хамтран ажиллах чиглэлээр туршлагатай байх.
- ННҮ, нийгмийн суурь судалгаа, орон нутгийн зөвлөлдөх уулзалтууд зохион байгуулах, нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө (НШТ) болон бусад холбогдох баримт бичгийг боловсруулах ажлуудыг удирдан зохион байгуулж байсан туршлагатай.
- Нөлөөлөлд өртсөн орон нутгийн иргэд, тэдгээрийн дунд эмзэг бүлгийн оролцоог хангах оролцогч талуудын оролцооны стратеги боловсруулах, хэрэгжүүлэх чадвартай байх.
- Салбар дундын багийг удирдан зохион байгуулах, манлайлах, төлөвлөх чадвартай байх.
- Дэлхийн Банкны Байгаль орчин, нийгмийн стандартын талаар мэдлэгтэй (давуу тал болно).
- Англи, Монгол хэлээр бичгийн болон аман харилцааны өндөр ур чадвартай, тайлан, бодлогын баримт бичиг, олон нийтийн зөвлөлдөх уулзалтын тайлан боловсруулж байсан туршлагатай.
- Бие даан ажиллах чадвартай, багийн гишүүдийг удирдан зохион байгуулах, багийн гишүүд болон бусад мэргэжилтнүүдтэй үр дүнтэй харилцаа холбоо тогтоож ажиллах чадвартай байх.

Багийн дэд ахлах- Байгаль орчны мэргэжилтэн
Ажлын туршлага/ мэргэжлийн ур чадвар

- Байгаль орчны менежмент, байгалийн шинжлэх ухаан болон бусад холбогдох чиглэлээр магистрын зэрэг эсвэл түүнээс дээш зэрэгтэй байх.
- Байгаль орчны хамгааллын чиглэлээр дор хаяж 8 жилийн туршлагатай, дэд бүтцийн төслүүдийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННҮ), байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) боловсруулж байсан туршлагатай байх.
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон мониторингийн төлөвлөгөө боловсруулах г.м БОННҮ боловсруулах ажлыг удирдах, суурь мэдээлэл цуглуулах, чадвартай.
- Дэлхийн Банк, АХБ болон бусад олон улсын байгууллагууд, төслүүдэд зөвлөх үйлчилгээ үзүүлж байсан туршлагатай байх.
- Дэлхийн Банкны Байгаль орчин, нийгмийн стандартын талаар мэдлэгтэй (давуу тал болно).
- Англи, Монгол хэлээр бичгийн болон аман харилцааны өндөр ур чадвартай, дотоодын холбогдох хууль тогтоомжийн дагуу баримт бичиг боловсруулсан туршлагатай.
- Төслийн нөлөөллийн үнэлгээний цогц байдлыг хангах үүднээс нийгмийн хамгааллын болон бусад техникийн мэргэжилтнүүдтэй нягт хамтран ажиллах чадвартай байх.

Нүүлгэн шилжүүлэлтийн мэргэжилтэн
Ажлын туршлага/ мэргэжлийн ур чадвар

- Газар зохион байгуулалт, хот төлөвлөлт болон бусад чиглэлээр магистраас доошгүй зэрэгтэй.
- Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлт, Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө (НШТ) боловсруулах чиглэлээр дор хаяж 5 жилийн туршлагатай, дэд бүтцийн төслүүдэд нүүлгэн шилжүүлэлт зохион байгуулж байсан туршлагатай.
- Нийгмийн нөлөөллийн үнэлгээ (ННҮ) хийх, нүүлгэн шилжүүлэлтийн үйл явцыг удирдах, үндэсний хууль тогтоомж болон олон улсын стандартад нийцүүлэн ажиллах туршлагатай.
- Нүүлгэн шилжүүлэлтийн асуудлаар гомдол барагдуулах механизм боловсруулах, хэрэгжүүлэх туршлагатай.
- Дэлхийн Банкны Байгаль орчин, нийгмийн стандартууд, ялангуяа БОНС 5-ийн мэдлэгтэй бол давуу тал болно.
- Англи, Монгол хэлээр бичгийн болон аман харилцааны ур чадвартай, тодорхой, иж бүрэн техникийн тайлан боловсруулах чадвартай.
- Газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх чиглэлээр орон нутгийн иргэд, төрийн байгууллага, оролцогч талуудтай зөвлөлдөх уулзалтуудыг удирдан зохион байгуулж байсан туршлагатай.

Биологийн олон янз байдлын мэргэжилтэн
Ажлын туршлага/ мэргэжлийн ур чадвар

- Биологийн олон янз байдлын менежмент, байгаль орчны хамгааллын чиглэлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй ;
- Биологийн олон янз байдлыг хамгаалах төлөвлөгөө боловсруулах, мониторингийн шалгуур үзүүлэлт боловсруулах чиглэлээр 5-аас доошгүй жилийн туршлагатай.
- Дэлхийн Банк, АХБ болон бусад олон улсын байгууллагууд, төслүүдэд зөвлөх үйлчилгээ үзүүлж байсан туршлагатай.
- Биологийн олон янз байдлыг хамгаалах, тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн талаарх олон улсын арга аргачлалын талаар мэдлэгтэй.
- Техникийн түвшинд ойлгомжтой, товч бичих чадвартай, англи, монгол хэлний өндөр түвшний мэдлэгтэй.

Хөрсний мэргэжилтэн
Ажлын туршлага/ мэргэжлийн ур чадвар

- Хөрс судлал, геологи, холбогдох чиглэлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй.
- Хөрсний шинжилгээ, хөрсний элэгдэл, хөрс хамгаалах чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай.
- Хөрсний судалгаа, нөлөөллийн үнэлгээ хийх, хөрс хамгаалах чиглэлээр бодит туршлагатай байх.
- Дэлхийн Банк, АХБ болон бусад олон улсын байгууллагууд, төслүүдэд зөвлөх үйлчилгээ үзүүлж байсан туршлагатай.
- Хөрс хамгаалах, газар ашиглалтын төлөвлөлттэй холбоотой үндэсний холбогдох хууль тогтоомж, хөрсний нөхөн сэргээлт, менежментийн олон улсын шилдэг туршлагын талаар мэдлэгтэй байх.
- Англи, Монгол хэлээр бичгийн болон аман харилцааны ур чадвартай, техникийн тайлан боловсруулах чадвартай байх.

Усны мэргэжилтэн
Ажлын туршлага/ мэргэжлийн ур чадвар

- Ус судлал, усны нөөцийн менежмент эсвэл холбогдох чиглэлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй.
- Усны нөөцийн үнэлгээ хийх, гидрологийн загварчлал, усны чанарын мониторингийн чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай.
- Ус хангамж, бохир усны менежмент, дэд бүтцийн усны системд үзүүлэх нөлөөллийн судалгааг хийж байсан туршлагатай.
- Дэлхийн Банк, АХБ болон бусад олон улсын байгууллагууд, төслүүдэд зөвлөх үйлчилгээ үзүүлж байсан туршлагатай.
- Усны нөөцийн хамгааллын талаарх үндэсний хууль тогтоомж, олон улсын усны менежментийн талаар мэдлэгтэй.
  Англи, Монгол хэлээр бичгийн болон аман харилцааны ур чадвартай, техникийн тайлан боловсруулах чадвартай

Хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын (ХАБЭА) мэргэжилтэн
Ажлын туршлага/ мэргэжлийн ур чадвар

- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй болон холбогдох чиглэлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй.
- Дэд бүтцийн төслүүдэд эрсдэлийн үнэлгээ, ажлын аюулын дүн шинжилгээ, ХАБЭА-н арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай.
- Дэлхийн Банк, АХБ болон бусад олон улсын байгууллагууд, төслүүдэд зөвлөх үйлчилгээ үзүүлж байсан туршлагатай.
- Үндэсний хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн зохицуулалтууд, олон улсын стандартыг мэддэг байх (ISO 45001 гэх мэт).
- Англи, Монгол хэлээр бичгийн болон аман харилцааны ур чадвартай, тодорхой техникийн тайлан бичих чадвартай байх.

ArcGIS мэргэжилтэн
Ажлын туршлага/ мэргэжлийн ур чадвар

- Газарзүй, газарзүйн мэдээллийн шинжлэх ухаан, хот төлөвлөлт эсвэл холбогдох чиглэлээр бакалаврын зэрэгтэй.
- Газарзүйн мэдээллийн систем (ГМС), ялангуяа ArcGIS программ хангамжийн мэргэшсэн сертификат эсвэл ахисан түвшний сургалтад хамрагдсан байх (давуу тал болно).
- ГМС-ийн шинжилгээ, зураглал, ялангуяа хот байгуулалт, байгаль орчны төсөлд 3-5-аас доошгүй жил ажилласан туршлагатай.
- Орон зайн шинжилгээ, зураглал, өгөгдлийн дүрслэлд зориулж ArcGIS программ хангамжийг ашиглах туршлагатай.
- Томоохон газарзүйн мэдээллийн өгөгдөл, багцтай ажиллах, орон зайн загварчлал хийх, өндөр чанартай газрын зураг, тайлан гаргах туршлагатай.

- ГМС-ийн өгөгдлийг байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээтэй нэгтгэх чадвартай байх.

Олон нийт, талуудын оролцоо хариуцсан мэргэжилтэн
Ажлын туршлага/ мэргэжлийн ур чадвар

- Олон нийтийн харилцаа, сэтгүүл зүй, болон холбогдох бусад чиглэлээр бакалаврын зэрэгтэй байх.
- Оролцогч талуудын хамтын ажиллагаа, олон нийттэй харилцах стратегийн талаар мэргэшсэн сертификаттай бол давуу тал болно.
- Байгаль орчин болон дэд бүтцийн төслүүдийн хүрээнд оролцогч талуудын оролцоог хангах төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх чиглэлээр 5-аас доошгүй жилийн туршлагатай.
- Олон нийтийн санал хүсэлтийг цуглуулах, олон нийтийн уулзалт, фокус бүлгийн ярилцлага,судалгаа зохион байгуулах зэргээр орон нутгийн иргэдийн саналыг авах туршлагатай байх.
- Тайлан, хэвлэлийн мэдээ, мэдээллийн хуудас, сошиал медиа контент зэрэг материалыг боловсруулах туршлагатай, бичгийн болон аман харилцааны маш сайн ур чадвартай байх.
- Төрийн байгууллагууд, орон нутгийн иргэд, ТББ-ууд болон зорилтот бүлгийн иргэдийг уулзалтад үр дүнтэй татан оролцуулах чадвартай байх.
- Санал, гомдлыг барагдуулах механизмыг зохицуулах, олон нийтийн санаа зовнилыг үр дүнтэй, ил тод шийдвэрлэх чиглэлээр ажилласан туршлагатай байх.

9. Төлбөрийн хуваарь

Төлбөрийг дараах үе шатуудыг амжилттай гүйцэтгэсний дараа, гүйцэтгэлийн үндсэн дээр хийнэ.

1. **Анхны төлбөр** : Эхлэлийн тайлан, ажлын төлөвлөгөөг хүлээн авч баталгаажуулсны дараа гэрээний **нийт үнийн дүнгийн 20%-ийг** төлнө.
2. **Завсрын төлбөр**: Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний (БОННҮ) тайлангийн төсөл болон бусад байгаль орчин, нийгмийн тайлангуудын төсөл, суурь өгөгдөл, мэдээллүүдийг хүлээн авсны дараа гэрээний **нийт үнийн дүнгийн 40%-ийг** төлнө.
3. **Эцсийн төлбөр** : БОННҮ-ий тайлан болон бусад Байгаль орчин, нийгмийн тайлангуудыг захиалагч болон Дэлхийн Банк бичгээр баталгаажуулсны дараа гэрээний **нийт үнийн дүнгийн 40%-ийг** төлнө.

ХАВСРАЛТ 1: БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ЖИШИГ ЗАГВАР[9]

Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээнд дараах агуулгыг тусгана.

(а) Хураангуй дүгнэлт

- Үндсэн үр дүн, санал болгож буй арга хэмжээг товч дүгнэн тусгана.

(б) Бодлого, хууль эрхзүйн орчин

- Төслийн хүрээнд байгаль орчин, нийгмийн үнэлгээ хийхэд холбогдох хууль эрхзүйн болон институцийн хүрээг шинжилнэ. Үүнд БОНС1-д заасан дараах асуудлууд багтана, тухайлбал :
  - Монгол Улсын бодлогын зохицуулалт, үндэсний хууль тогтоомж, байгаль орчин, нийгмийн асуудалтай холбоотой институцийн чадавх(төслийн хэрэгжилттэй холбоотой); улсын нөхцөл байдал, төслийн орчин; Монгол улсын байгаль орчин, нийгмийн хамаарал бүхий судалгаанууд.
  - Байгаль орчин, нийгмийн үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө; төслийн хувьд хамааралтай олон улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу улсын үүрэг; БОНС-ын дагуу тавигдах хамааралтай шаардлагууд болон
  - Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны удирдамж (БОЭМАА), холбогдох олон улсын шилдэг туршлага.

- Монгол Улсад одоогоор хүчин төгөлдөр мөрдөгдөж буй байгаль орчин, нийгмийн чиглэлээрх хууль эрхзүйн зохицуулалтууд болон БОНС-ыг харьцуулж, хийдлийн шинжилгээ хийнэ.
- Хамтран санхүүжүүлэгчид байгаа тохиолдолд тэдгээрийн байгаль орчин, нийгмийн шаардлагыг тодорхойлж, үнэлнэ.

(в) Төслийн тодорхойлолт

- Төлөвлөж буй төсөл болон төслийн газар зүй, байгаль орчин, нийгэм, цаг хугацааны нөхцөл байдал, хүчин зүйлүүд, цаашлаад төслийн байршлаас гадна шаардлага гарч болзошгүй хөрөнгө оруулалтын төрлүүд (жишээлбэл, зориулалтын шугам хоолой, зам, эрчим хүчний хангамж, усан хангамж, орон сууц, түүхий эд, бүтээгдэхүүн хадгалах байгууламж г.м), төслийн үндсэн ханган нийлүүлэгчид зэргийг товч тайлбарлана.
- Төслийн нарийвчилсан мэдээллийг үндэслэн БОНС1-10-т заасан шаардлагуудыг хангах төлөвлөгөөний хэрэгцээ шаардлагыг тодорхойлно.
- Төслийн шууд ба шууд бус, хуримтлагдсан нөлөөлөлд өртөж болзошгүй төслийн талбай, газар нутгийг харуулсан нарийвчилсан мэдээлэл бүхий газрын зургийг боловсруулж, багтаана.

(г) Суурь өгөгдөл

- Төслийн байршил, загвар, зураг төсөл, үйл ажиллагаа, нөлөөллийг бууруулах арга хэмжээний талаарх шийдвэр гаргалттай холбоотой байгаль орчин, нийгмийн суурь өгөгдлийг нарийвчлан тодорхойлно. Үүнд өгөгдлийн үнэн зөв, найдвартай байдал, эх сурвалж, цаашлаад төслийн үйл ажиллагааг тодорхойлох, төлөвлөх, хэрэгжүүлэх шатуудыг хамарсан огнооны талаарх мэдээллийг багтаана.
- Боломжит өгөгдлийн хамрах хүрээ, чанар, өгөгдлийн гол дутагдал болон таамаглалтай холбоотой тодорхойгүй байдал зэргийг тодорхойлж, үнэлнэ.

---

[9]Энэхүү загварыг Дэлхийн банкны БОНС1-ийн удирдамжийн тэмдэглэлд тусгасан ерөнхий шаардлагаас эшлэсэн болно. Уг загвар нь тойм хэлбэртэй бөгөөд төслийн онцлог, тодорхой нөхцөл, шаардлагад үндэслэн өөрчлөх ёстойг анхаарна уу.

- Байгаа мэдээлэлд үндэслэн судалгаанд хамрагдах бүс нутгийн хамрах хүрээг тодорхойлж, төслийн хэрэгжилт эхлэхээс өмнөх физик, биологийн, нийгэм-эдийн засгийн нөхцөл байдлыг тодорхойлж үнэлнэ.
- Төсөлтэй шууд хамааралгүй боловч төслийн бүсэд хийгдэх одоогийн болон төлөвлөсөн хөгжлийн үйл ажиллагааг харгалзан үзнэ.

(д) Байгаль орчин, нийгмийн эрсдэл ба нөлөөлөл

- Төслийн байгаль орчин, нийгмийн бүхий л эрсдэл, нөлөөллийг харгалзан үзнэ. Үүнд БОНС2-8-д тусгайлан тодорхойлсон байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөлөл, мөн ESS1-ийн 28-р зүйлд тодорхой дурдсан эрсдэл, нөлөөллүүд, төслийн онцлог болон нөхцөл байдлаас үүдэн гарч болох бусад байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллүүд багтана.

(е) ESCoP болон тухайн талбайн нөлөөллийг бууруулах арга хэмжээг боловсруулах

- Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, арилгах боломжгүй үлдэгдэл сөрөг нөлөөллийг тодорхойлж, хүлээн зөвшөөрч болохуйц үлдэгдэл нөлөөллийн хэмжээг тогтоох.
- Эмзэг, өртөмтгий хүн амын бүлэг төслийн сөрөг нөлөөлөлд хэт ихээр, тэгш бусаар өртөхөөс сэргийлж, тухайн хүн амын бүлгийн онцлог, ялгаатай байдалд чиглэсэн тусгай арга хэмжээг тодорхойлох.
- Байгаль орчин, нийгмийн нөлөөллийг сааруулах боломж, нөлөөллийг сааруулах зорилт бүхий арга хэмжээний урсгал зардал, хөрөнгө ба тэдгээрийн орон нутгийн нөхцөлд тохиромжтой эсэх, санал болгож буй нөлөөллийг бууруулах арга хэмжээтэй холбоотой институцийн сургалт ба мониторингийн шаардлага зэргийг үнэлэх.
- Нарийвчлан үнэлгээ хийх шаардлагагүй асуудлуудыг тодорхойлж, үндэслэлийг тайлбарлана.

(ё) Хувилбаруудын шинжилгээ

- Төлөвлөж буй төслийн талбай, технологи, загвар, үйл ажиллагааны хувилбаруудыг, “төслийг хэрэгжүүлэхгүй” байх нөхцөлийн хамтаар харьцуулж, хувилбар бүрийн тэдгээрийн байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийг системтэйгээр үнэлнэ.
- Байгаль орчин, нийгмийн нөлөөллийг бууруулах харилцан адилгүй хувилбаруудын хэрэгжих боломж, хувилбаруудын хөрөнгө оруулалтын болон урсгал зардал, тухайн орон нутгийн нөхцөлд тохиромжтой эсэх, мөн эдгээр арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой институцийн сургалт, хяналт, мониторингийн шаардлагуудыг үнэлнэ.
- Хувилбар бүрийн байгаль орчин, нийгмийн нөлөөллийг боломжтой хэмжээнд тооцож, боломжтой тохиолдолд эдийн засгийн тооцооллыг багтаах.

(ж) Төслийн загвартай холбоотой арга хэмжээ

- Санал болгож буй төслийн загварыг яагаад сонгож буй талаар тодорхой үндэслэл гаргаж, тухайн загварт хамаарах БОЭМАА-ны удирдамжийг тодорхойлох. Хэрэв тухайн БОЭМАА-ны удирдамжийг дагаж мөрдөх боломжгүй гэж үзвэл олон улсын сайн туршлагуудтай нийцсэн бохирдлыг бууруулах арга хэмжээ, ялгарлын түвшнийг яагаад сонгосон үндэслэлийг тайлбарлана.

(з) Байгаль орчин, нийгмийн зорилтын төлөвлөгөө (БОНЗТ)-ний голлох арга хэмжээ ба үйл ажиллагаанууд

- БОНС-ийн шаардлагыг хангахад төслийн хүрээнд шаардлагатай гол арга хэмжээ, үйл ажиллагаанууд болон хэрэгжүүлэх хугацааг нэгтгэн харуулдаг. Эдгээрийг Байгаль орчин, нийгмийн зорилтын төлөвлөгөө (БОНЗТ) боловсруулахад ашиглана.

(и) Хавсралт

- Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээг боловсруулахад оролцсон хувь хүмүүс эсвэл байгууллагуудын жагсаалт.
- Ашигласан материалын жагсаалт (олон нийтэд нээлттэй хэвлэгдсэн эсвэл хаалттай)
- Оролцогч талууд, түүний дотор нөлөөлөлд өртөж болзошгүй иргэд болон бусад талуудтай хийсэн уулзалт, зөвлөгөөн, санал асуулгын бүртгэл, уулзалтын

тэмдэглэлүүд. Уулзалтын тэмдэглэлд нөлөөлөлд өртөж болзошгүй иргэд болон бусад оролцогч талуудын саналыг авахад ашигласан аргазүйг багтаасан байна.
- Үндсэн тайланд дурдсан мэдээлэлтэй холбоотой өгөгдлүүдийг харуулсан хүснэгтүүд.
- Дагалдах тайлангууд болон төлөвлөгөөнүүд.

ХАВСРАЛТ 2 БОНМТ-НИЙ ЖИШИГ ЗАГВАР[10]

БОНМТ нь төслийн хэрэгжилт, үйл ажиллагааны явцад үүсэж болзошгүй байгаль орчин, нийгмийн эрсдэл, сөрөг нөлөөллийг саармагжуулах, арилгах, хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд хүртэл бууруулахад чиглэсэн, мониторингийн хяналт, институцийн арга хэмжээнүүдийн багц юм. Мөн эдгээр арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай үйл ажиллагаа, арга хэмжээг багтаадаг. Зээлдэгч нь дараах зүйлсийг БОНМТ-д багтаах шаардлагатай. Үүнд: (а) болзошгүй сөрөг нөлөөллийн хариу арга хэмжээг тодорхойлох, (б) эдгээр арга хэмжээнүүдийг үр дүнтэй, цаг хугацаанд нь хэрэгжүүлэхэд шаардагдах нөхцөлийг тодорхойлох, (в) эдгээр шаардлагыг хангах арга замыг тайлбарлах.
Төслийн үйл ажиллагааны онцлог, нарийн төвөгтэй байдлаас хамааран БОНМТ-г бие даасан баримт бичиг болгон бэлтгэж болох ба зарим тохиолдолд БОННҮ-ний нэг хэсэг байж болно. БОНМТ-ийн агуулга:

(а) Бууруулах арга хэмжээ
- **БОНМТ нь** сөрөг нөлөөллийг хүлээн зөвшөөрөгдөх түвшинд бууруулах арга хэмжээнүүдийг тодорхойлж, нөлөөллийг бууруулах шаталсан зарчмын дагуу төлөвлөгөө гаргана. Хэрэв шаардлагатай бол нөхөн төлөх арга хэмжээнүүдийг багтаана. Тухайлбал:
- Урьдчилан таамаглаж буй байгаль орчин, нийгмийн бүхий л сөрөг нөлөөллийг тодорхойлж, нэгтгэнэ. (уугуул иргэдтэй холбоотой эсвэл албадан нүүлгэн шилжүүлэлтэд хамаарах нөлөөлөл);
- Нөлөөллийг сааруулах арга тус бүрийн холбогдох төрөл, шаардагдах нөхцөл (жишээ нь, тасралтгүй эсвэл гэнэтийн тохиолдлын үед) зэргийг зураг төсөл, тоног төхөөрөмжийн тодорхойлолт болон үйл ажиллагааны журмын хамт техникийн нарийвчлалтай өгөгдлөөр тайлбарлана.
- эдгээр арга хэмжээний байгаль орчин, нийгмийн болзошгүй нөлөөллийг тооцоолно
- Төслийн бусад төлөвлөгөөнүүдтэй (жишээлбэл, албадан нүүлгэн шилжүүлэлт, уугуул иргэд, эсвэл соёлын өвтэй холбоотой) нийцүүлж боловсруулна.

(б) Хяналт шинжилгээ

БОНМТ-д хяналт-шинжилгээний зорилгыг тодорхой тусгаж, байгаль орчин, нийгмийн үнэлгээгээр тодорхойлогдсон нөлөөлөл болон БОНМТ-д дурдсан бууруулах арга хэмжээнүүдтэй уялдсан хяналт-шинжилгээний төрөл, үйл явцыг тодорхойлно. Тухайлбал, хяналт-шинжилгээний хэсэгт дараах зүйлийг тусгана:
(а)Хяналт-шинжилгээний арга хэмжээний тодорхой тайлбар, техникийн дэлгэрэнгүй мэдээлэл, үүнд: хэмжих үзүүлэлтүүд, ашиглах аргазүй, дээж авах байршлууд, хэмжилтийн давтамж, илрүүлэх хязгаар (шаардлагатай бол), мөн залруулах арга хэмжээ авах шаардлагатайг илтгэх босго хэмжээг тодорхойлно.
(б) Хяналт-шинжилгээ болон тайлагналын журам, үүнд: (i) тодорхой нөлөөллийг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай нөхцөл байдлыг эрт илрүүлэх боломжийг бүрдүүлэх, (ii) нөлөөллийг бууруулах явц, үр дүнгийн талаарх мэдээлэл хүргэх.

(в) Институцийн зохион байгуулалт

---

[10]Энэхүү загварыг Дэлхийн банкны БОНС1-ийн удирдамжийн тэмдэглэлд тусгасан ерөнхий шаардлагаас эшлэсэн болно. Уг загвар нь тойм хэлбэртэй бөгөөд төслийн онцлог, тодорхой нөхцөл, шаардлагад үндэслэн өөрчлөх ёстойг анхаарна уу.

БОНМТ-д болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, хяналт тавих арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай байгаль орчин, нийгмийн менежментийн байгууллагын бүтэц, үүрэг хариуцлагыг тодорхой зааж өгдөг. Энэ хэсэгт төслийн хэрэгжүүлэгч талууд, гэрээлэгчид, хяналт тавих байгууллагууд болон холбогдох төрийн байгууллагуудын БОНМТ-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой гүйцэтгэх үүргийг тусгана. Мөн барилгын өмнөх үе шат, барилгын үе шат, ашиглалтын явцад байгаль орчны хамгааллын үйл ажиллагааг тасралтгүй сайжруулах, хяналт тавих байгууллагуудыг тодорхойлно.

(г) Чадавх бэхжүүлэх ба сургалт

- Төслийн байгаль орчин, нийгмийн бүрэлдэхүүн хэсэг, нөлөөллийг бууруулах арга хэмжээг цаг тухайд нь, үр дүнтэй хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхийн тулд БОНМТ-г боловсруулахад төслийн хэрэгжих байршилд эсвэл байгууллага, яамны түвшинд хариуцагч талууд байгаа эсэх, тэдгээрийн үүрэг, чадамжийг байгаль орчин, нийгмийн үнэлгээгээр үнэлж мэдээллийн эх үүсвэр болгон ашиглана.
- Түүнчлэн, БОНМТ нь нөлөөллийг сааруулах болон мониторингийн арга хэмжээг (жишээ нь хэрэгжилт, удирдлага, албадлага, хэрэгжилтийн хяналт, залруулах үйл ажиллагаа, санхүүжилт, тайлагнах, ажилтнуудын сургалт г.м) хэрэгжүүлэх талыг тодорхойлсон институцийн зохицуулалтыг тодорхой тайлбарлана.
- БОНМТ нь хэрэгжилтийг хариуцах байгууллагын байгаль орчин, нийгмийн менежментийн чадамжийг бэхжүүлэхийн тулд хариуцагч талуудыг тогтоож, өргөжүүлэх, ажилтнуудыг сургах, нөлөөллийг сааруулах арга хэмжээний хэрэгжилтийг дэмжихэд шаардлагатай нэмэлт арга хэмжээ болон байгаль орчин, нийгмийн үнэлгээний талаар бусад зөвлөмжүүдийг санал болгодог.

(д) Хэрэгжүүлэх хуваарь ба зардлын тооцоо

- БОНМТ нь бүх гурван бүрдэл хэсэгт (нөлөөллийг сааруулах, мониторинг ба чадамжийг нэмэгдүүлэх) дараах зүйлсээр хангана. Үүнд: (а) төслийн ерөнхий хэрэгжилтийн төлөвлөгөөний үе шат, зохицуулалтыг харуулсан төслийн хүрээнд хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлэх хуваарь, (б) БОНМТ-г хэрэгжүүлэх хөрөнгө, урсгал зардлын тооцоо болон санхүүжилтийн эх үүсвэр. Эдгээр дүнг төслийн нийт зардлын хүснэгтэд нэгтгэнэ.

(е) БОНМТ-г төслийн үйл ажиллагаатай уялдуулах нь

- Зээлдэгчийн төсөл эхлүүлэх болон түүнийг дэмжих Дэлхийн Банкны шийдвэр нь БОНМТ (дангаар эсвэл БОНЗТ-нд тусгах байдлаар)-г үр дүнтэй хэрэгжих урьдчилсан нөхцөл юм. Үүний үр дүнд төлөвлөгөө тус бүрийн нөлөөллийг сааруулах, мониторингийн арга хэмжээ, үйл ажиллагаа болон институцийн үүрэг хариуцлага зэргийг хэрэгжүүлэх арга хэмжээ, үйл ажиллагаа тус бүрийг тодорхой зааж, холбогдох зардлыг төслийн ерөнхий төлөвлөлт, загвар, төсөв, хэрэгжилтэд тусгасан байх шаардлагатай.

ХАВСРАЛТ 3: ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ОРОЛЦООГ ХАНГАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИШИГ ЗАГВАР[11]

Чанарын өндөр түвшинд сайтар боловсруулсан ОТОХТ нь төслийн үйл ажиллагаанд оролцогч талуудын дунд ил тод байдал, итгэлцлийг бий болгож, төслийг боловсруулах, хэрэгжүүлэх үйл явцад тэдний идэвхтэй оролцоог хангадаг. Энэ нь оролцогч талуудын санал, зөвлөмж, шүүмжийг эртнээс шийдвэрлэх замаар асуудлыг ноцтой түвшинд газар авахаас сэргийлж, эмзэг, өртөмтгий зорилтот бүлгийг гадуурхахгүй байх боломжийг олгодог. Олон нийтийн ойлголт, хандлага болон оролцооны ач холбогдол өндөр байдаг хотын бүс нутагт хэрэгжих энэхүү төслийн хувьд ОТОХТ чухал ач холбогдолтой байх болно. Дэлхийн Банкны БОННС-10-т "Оролцогч талуудын оролцоо ба мэдээллийн ил тод байдал"-ийг шаардлагыг батгаасан байдаг бөгөөд "Зээлдэгч болон төслийн оролцогч талуудын

[11] *Тухайн загварын бүтэн хувилбартай дараах холбоосоор танилцана уу: https://thedocs.worldbank.org/en/doc/1c4a63fdbac0b98a1f80deb9becefe2d-0290012023/original/SEP-Template-for-HS-Risk-Projects202-. pdf*

хоорондын нээлттэй, ил тод оролцооны ач холбогдлыг олон улсын сайн туршлагын чухал хэсэг" гэж хүлээн зөвшөөрдөг. Зээлдэгч нар төслийн мөн чанар, цар хүрээ, түүний болзошгүй эрсдэл, сөрөг нөлөөллийн түвшинд тохирсон ОТОХТ-г боловсруулах шаардлагатай (13-р зүйл). Дэлхийн банк төсөлд үнэлгээ хийхээс өмнө төслийн үйл ажиллагаанд оролцогч талуудыг тодорхойлж , ОТОХТ-г аль болох эрт олон нийтэд танилцуулсан байх ёстой байдаг. Түүнчлэн БОНС10-ийн шаардлагын хүрээнд гомдол барагдуулах механизмыг (ГБМ) боловсруулж хэрэгжүүлэхийг шаарддаг ба ГБМ-д үндэсний хууль эрхзүйн шаардлага болон БОНС-ийн дагуу тавигдах шаардлагыг багтаасан байдаг.

Жишиг загвар:

1. Танилцуулга/төслийн мэдээлэл
2. ОТОХТ-ний зорилго/тайлбар
3. Төслийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрд хамаарах оролцогч талуудын тодорхойлолт, дүн шинжилгээ
    a. Арга зүй
    b. Нөлөөлөлд өртөж болзошгүй талууд
    c. Бусад сонирхогч талууд
    d. Эмзэг, өртөмтгий зорилтот хүн амын бүлгүүд
4. Талуудын оролцоог хангах хөтөлбөр
    a. Төслийн бэлтгэл үе шатад зохион байгуулсан талуудын оролцоог хангахад чиглэсэн үйл ажиллагааны хураангуй
    b. Төслийн оролцогч талуудын хэрэгцээ, шаардлага тэдний оролцоог хангах арга, хэрэгсэл, аргачлалын хураангуй
    c. Эмзэг, өртөмтгий зорилтот хүн амын бүлгийн санал бодлыг тусгах стратеги
5. Оролцогч талуудын оролцоог хэрэгжүүлэх нөөц ба үүрэг хариуцлага
    a. Хэрэгжүүлэх зохицуулалт ба нөөц
6. Гомдлын механизм
    a. Гомдлын механизмын тодорхойлолт
7. Хяналт ба тайлагнал
    a. ОТОХТ-г хэрхэн хянаж, тайлагнах тухай хураангуй (шалгуур үзүүлэлтийг багтаана)
    b. Оролцогч талуудад эргэн мэдээлэх

ХАВСРАЛТ 4: НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭЛТИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ЖИШИГ ЗАГВАР

Нүүлгэн шилжүүлэлтийн бодлогын баримт бичиг нь газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэлтээс үүдэж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, нөлөөлөлд өртсөн иргэдэд нөхөн олговор олгох, амьжиргааг нь сэргээхэд чухал үүрэгтэй. Энэ нь ялангуяа нүүлгэн шилжүүлэлт гарч болзошгүй үерийн хамгаалалтын байгууламжийн ойролцоох газруудад онцгой ач холбогдолтой. НШБББ-ийн үндсэн зорилго нь төсөл хэрэгжүүлэх явцад дэд төслүүд эсвэл төслийн бүрэлдэхүүн хэсгүүдэд мөрдөх нүүлгэн шилжүүлэлтийн зарчим, зохион байгуулалттай холбоотой зохицуулалт болон загварын шалгуурыг тодорхой болгоход оршино. Төслийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нарийвчилсан мэдээлэл, тухайлбал үерээс хамгаалах далангуудын загвар, байршил, газар ашиглалтын шаардлага тодорхой болсны дараа НШБББ-ийг сөрөг нөлөө, эрсдэлийн түвшинд нийцүүлэн Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө (НШТ) болгон өргөжүүлнэ. Дэлхийн банкны БОНС5 стандартын дагуу НШТ батлагдаж, хэрэгжихээс өмнө биет болон/эсвэл эдийн засгийн шилжилт хөдөлгөөнтэй холбоотой аливаа үйл ажиллагааг эхлүүлдэггүй.

БОНС-ын нийцэл:

- БОНС5 (Газар чөлөөлөлт, газар ашиглалтад тавих хязгаарлалт ба албадан нүүлгэн шилжүүлэлт) нь нүүлгэн шилжүүлэлтийн нөлөөллийг багасгах, нүүлгэн шилжүүлэлтийг тэгш, шударга зарчмаар явуулахыг шаарддаг.

- НШБББ нь нөлөөлөлд өртөж болзошгүй иргэдийг тогтоох, нөхөн олговор олгох, тэдний амьжиргааг сэргээх арга хэмжээг тодорхойлно. Цаашлаад (i) барилга байгууламж, үл хөдлөх хөрөнгөд учирсан хохирлыг нөхөн төлөх журам; (ii) иргэдийн нүүлгэн шилжүүлэлтэд үзүүлэх нөлөөлөлтэй холбоотой бодлого, журмын зохицуулалтууд уг баримт бичигт тусгагддаг. Эдгээр нь төслийн үнэлгээ дуусч, бүтээн байгуулалтын ажил эхлэхээс өмнө боловсруулагдах НШТ-д тусгагддаг.

НШБББ-ийн жишиг загвар нь дараах байдалтай байна.

1. Танилцуулга

   - Газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэхэд нөлөөлөл үүсгэж болзошгүй төслийн үйл ажиллагааны тойм.
   - Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөлт, хэрэгжилтийн удирдамж болох НШБББ-ийг бэлтгэх үндэслэл.
   - Газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаанд хяналт тавих, хэрэгжүүлэх үүрэг бүхий голлох төрийн байгууллагуудыг тодорхой чиг үүргийн хамт тодорхойлох.

2. Зорилтууд ба үндсэн зарчим

   - Нөлөөлөлд өртсөн иргэдэд (НӨИ) шударга хандах, олон улсын шилдэг туршлагад нийцүүлэх зэрэг НШБББ-ийн зорилгыг тодорхой илэрхийлэх.
   - Дэлхийн банкны Байгаль орчин, нийгмийн стандарт 5 (БОНС5)-д үндэслэсэн олон нийтэд ил тод мэдээлэх, оролцогч талуудтай зөвлөлдөх үйл явц, НӨИ-д нөхөн олговор олгох эрхийн матрицтай холбоотой гол зарчмуудыг тусгах.

3. Нүүлгэн шилжүүлэх төлөвлөлтийн үндсэн зарчмууд

   - Нүүлгэн шилжүүлэлтийг төлөвлөх, хэрэгжүүлэх явцад баримтлах зарчмуудын дэлгэрэнгүй тайлбар. Үүнд ил тод байдал, эрх тэгш байдал болон НӨИ-д үзүүлэх үр дүнгийн тогтвортой байдлыг онцлох.

4. Хууль эрх зүйн болон зохицуулалтын хүрээ

   - Газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгохтой холбогдсон Монгол Улсын хууль тогтоомжийг үнэлж, дүн шинжилгээ хийх.
   - Дэлхийн банкны БОНС5-ын холбогдох заалтуудын тайлбар, тэдгээрийг төсөлд хэрхэн хэрэгжүүлэх талаар тайлбарлах.
   - Монгол Улсын хууль эрхзүйн шаардлагууд болон Дэлхийн банкны БОНС5-ын шаардлагуудыг харьцуулсан дүн шинжилгээ хийж, хийдлийн шинжилгээ хийх.
   - Зөрүүг тодорхойлсон дэлгэрэнгүй дүн шинжилгээ болон нийцлийн матриц гаргаж, зөрүүг арилгах арга хэмжээг БОНС5-тай нийцүүлэх байдлаар боловсруулах.

5. Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөг бэлтгэх, батлах
   - Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө (НШТ)-г боловсруулах болон батлах үйл явцыг тайлбарлахад энэ хэсэг төвлөрнө. Үүнд Төсөл хэрэгжүүлэх нэгжийн (ТХН) хамгааллын мэргэжилтэнтэй хамтран нүүлгэн шилжүүлэлтийн нөлөөллийг тодорхойлох, үнэлэх дүн шинжилгээг эхлүүлэхээс гадна, тэдгээр нөлөөллийг бууруулах болон зайлсхийх арга хэмжээнүүдийг нарийвчлан тусгана. Түүнчлэн НӨИ-ийг бүртгэх, хөрөнгийн үнэлгээ хийх, нөхөн төлбөрийн үнийг тогтоох журмыг нарийвчлан зааж өгөх шаардлагатай. Оролцогч талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны аргуудыг тайлбарлана. Тухайлбал, Монгол болон Англи хэл дээр Төслийн мэдээллийн товхимол (ТМТ)-ыг тараах, НӨХ-ийн санал, зөвлөмжийг авах үүднээс НШТ-г олон нийтэд ил болгох, зөвлөлдөх үйл явцын талаар нарийвчлан дурдана.Мөн нөхөн төлбөр авах эрх бүхий этгээдийг тодорхойлох

шалгуур, нөхөн төлбөрийн заалтууд, дэлгэрэнгүй төсөв, Дэлхийн Банкны БОНС5 болон НШТ-ийн хүрээнд нийцлийг хангуулах хяналтын механизмын талаарх мэдээллийг багтаана.

6. Урьдчилан тооцоолсон хүн амын шилжилт хөдөлгөөн
   - нүүлгэн шилжүүлэлтэд өртөх иргэдийн тоо болон ангиллыг тооцоолно.

7. Нөхөн төлбөрийн шалгуур
   - НӨХ-ийн ангилал ба ангиллыг тодорхойлох шалгуур үзүүлэлтүүд.

8. Үнэлгээний арга зүй
   - Айл өрх, дэлгүүр, барилга байгууламж, газар, зэрэг нөлөөлөлд өртсөн хөрөнгийг үнэлэх аргыг тодорхойлно. Хэрэв аж ахуй нэгж нүүлгэн шилжүүлэлтэд өртөх тохиолдолд байнгын болон түр зуурын орлогын алдагдлыг мөн ДБ-ны БОНС5 шаардлагын дагуу багтаана.

9. Хэрэгжүүлэх үйл явц
   - Нүүлгэн шилжүүлэлттэй холбоотой бүхий л үйл ажиллагааг хэрэгжүүлэх хугацаатай хуваарийг гаргаж, барилгын ажил эхлүүлэхээс өмнө бүх нөхөн төлбөрийг олгосон байх нөхцөлийг хангана.

10. Нүүлгэн шилжүүлэлтийн зөвлөлдөх болон мэдээлэл түгээх зохицуулалт
    - Нүүлгэн шилжүүлэлтийн нөлөөлөлтэй холбоотойгоор НӨИ болон бусад оролцогч талуудтай зөвлөлдөх, мэдээлэл түгээх үйл явцад анхаарна. Үүнд тооллогын судалгаа хийх, Төслийн мэдээллийн товхимол тараах, Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөний төсөл танилцуулах, санал шүүмж хүлээн авах зэрэг гол үйл ажиллагаануудыг тодорхойлно. НШТ-ийн эх болон эцсийн хувилбарыг хүртээмжтэй хэлбэрээр тодорхой хугацаанд нийтэд ил болгох шаардлагыг мөн багтаана.

11. Газар чөлөөлөхтэй холбоотой өргөдөл, гомдол барагдуулах
    - Газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой асуудлыг шийдвэрлэхэд зориулсан Гомдол барагдуулах механизм (ГБМ)-ыг тодорхойлно. Үүнд гомдлын мөн чанар, ач холбогдлоос хамаарч шийдвэрлэх түвшин, гомдлыг бүртгэх, шийдвэрлэх үйл явц, нэргүй гомдол гаргах механизм, ГБМ-ын хүрээнд шийдвэрлэх боломжгүй маргааныг шийдвэрлэхэд гүйцэтгэх шүүхийн үүргийг тодорхойлсон байх ёстой. Түүнчлэн ГБМ-ын шударга, ил тод байдлыг хангахын зэрэгцээ асуудлыг түргэн шуурхай шийдвэрлэх, дотоодод хүчин төгөлдөр мөрдөж буй хууль, журамд нийцүүлэхийг чухалчлах ёстой. Цаашлаад ГБМ нь гомдлыг үр дүнтэйгээр хүлээн авах Засгийн газрын сувгуудыг ашиглах чиглэлээр анхаарал хандуулах шаардлагатай.

12. Санхүүжилт ба институцийн зохион байгуулалтын
    - Энэ хэсэгт нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, түүний дотор зардлын тооцоо, төсөв боловсруулах зэрэг байгууллагын үүрэг хариуцлагыг тодорхойлох ёстой. Урьдчилан тооцоолоогүй гэнэтийн зардлыг нөхөх, нөхөн олговрын урсгалыг тоймлох, нөхөн олговрыг барилгын ажил эхлэхээс өмнө бүрэн барагдуулахтай санхүүжилтийн эх тоймлоно. Мөн санхүүгийн гүйлгээний ил тод байдал, захиргааны болон нүүлгэн шилжүүлэлтийн зардлыг (нэг удаагийн газар чөлөөлөх, нүүх зардал, нэг удаагийн түр суурьшуулах дэмжлэг, шилжүүлгийн зардал г.м) төсөвт тусгах талаар анхаарах ёстой.

13. Нүүлгэн шилжүүлэлтийн хяналт-шинжилгээ
    - Нүүлгэн шилжүүлэлтийн үйл ажиллагаанд хяналт тавих хяналтын тогтолцоог тодорхойлж, хэрэгжилтийн явцын хяналт, асуудлыг шийдвэрлэх, Дэлхийн Банканд тайлагнахтай холбоотой ТХН-ийн үүргийг тодорхойлно. Энэ хэсэгт мөн

НШТ-ийн нийцлийг хянах шалгуур үзүүлэлтүүд, зөвлөлдөх уулзалт болон санал гомдлын бүртгэлийг баримтжуулах, санхүүгийн тайлагнал зэргийг багтаана. Тайлан нь бодлогын зорилгуудыг хангах болон нүүлгэн шилжүүлэлтийн бүх үйл явцын ил тод байдлыг баталгаажуулна. Хяналт шинжилгээний тайлагнал нь нүүлгэн шилжүүлэлтийн үйл явцын ил тод байдлыг баталгаажуулах ёстой.

ХАВСРАЛТ 5: ХӨДӨЛМӨРИЙН УДИРДЛАГЫН ЖУРМЫН ЖИШИГ ЗАГВАР[12]

ХУЖ нь нь төслийн бүх ажилчдын, үүнд шууд ажилчид, гэрээт ажилчид болон гол ханган нийлүүлэгчдийн ажиллах нөхцөлийг аюулгүй, шударга байдлаар хангахад чухал үүрэгтэй. Энэхүү төлөвлөгөө нь ажилд авах, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл, хөдөлмөрийн аюулгүй байдал ба эрүүл ахуй (ХАБЭА), мөн ажилчдын гомдол шийдвэрлэх механизмын протоколыг тодорхойлдог.
Үерээс хамгаалах болон бохир усны шугам сүлжээний шинэчлэлтийн төслийн үйл ажиллагааны хүрээнд, биеийн хүчний өндөр ачаалал шаардсан, эрсдэл дагуулсан барилгын үйл ажиллагаа явуулах үед ХУЖ нь ажлын байрны осол, албадан хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн нөхцөлийн маргаантай холбоотой үүсч болзошгүй эрсдэлийг багасгах ач холбогдолтой.

БОНС-ийн нийцэл:

- БОНС2 (Хөдөлмөр ба ажлын нөхцөл) нь ялгаварлан гадуурхахгүй байх, тэгш боломжоор хангагдах, зохион байгуулалтад орох эрх зэрэгт төвлөрч, шударга хөдөлмөрийн практикийг дагаж мөрдөхийг үүрэг болгодог.
- ХУЖ нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомжууд, ДБ-ны БОНС2-т заасан шаардлагууд болон ХАБЭА-н удирдамжийг дагаж мөрдөхийн зэрэгцээ эдгээр зарчмуудыг баримтална.

Жишиг загвар:

- Төслийн хүрээнд ашиглах ажиллах хүчний ерөнхий тойм
    - Төслийн ажилчдын тоо: Төсөлд ажиллах нийт ажилчдын тоо болон төрөл (шууд ажилчид, гэрээт ажилчид, орон нутгийн ажилчид г.м). Хэрэв тоо тодорхойгүй бол урьдчилсан тооцоо гаргах.
    - Төслийн ажилчдын шинж чанар: Ажилчдын хүйс, нас, орон нутгийн эсвэл гадаад ажилчид, эмэгтэй ажилчид, мөн 18 нас хүрээгүй ажиллах хүчний ерөнхий төлөв.
    - Ажиллах хүчний шаардлагын хугацаа: Ажиллах хүчний тоо, байршил, ажил төрөл, ур чадварын хэрэгцээг цаг хугацаа, дараалын хувьд тодорхойлох.
    - Гэрээт ажилчид: Гэрээт байгууллагууд болон тэдгээрийн ажилчдын тоо, төрөл, ажиллах хүчийг ямар замаар авах талаар (зуучлагч гэх мэт). Хэрэв төслийн ажилчдыг зуучлагч, дундын этгээд эсвэл төлөөлөгчдийн тусламжтайгаар ажилд авах магадлалтай бол, энэ тухай болон ийм аргаар хэдэн ажилчин авахыг тооцоолсон мэдээллийг тэмдэглэх шаардлагатай.
    - Цагаач ажилчид: Хэрэв төсөл дээр цагаач ажилчид (дотоодын болон гадаадын) ажиллах магадлалтай эсэхийг тодорхойлж дэлгэрэнгүй мэдээлэл өгөх.

- Хөдөлмөрийн гол болзошгүй эрсдэлийн үнэлгээ
    - Төслийн үйл ажиллагаа: Ажилчдын гүйцэтгэх төрөл бүрийн ажлууд болон байршлыг тодорхойлох.

[12] *ХУЖ-ын загварын бүтэн хувилбарыг зөвлөхийн хүсэлтийн дагуу хүргүүлэх боломжтой.*

- Хөдөлмөрийн голлох эрсдэлүүд: Төсөлтэй холбоотой байж болох хөдөлмөрийн гол эрсдэлүүд (жишээлбэл, БОНС2-д тодорхойлсон эрсдэлүүдийг үзнэ үү). Үүнд, жишээлбэл:

    - Өндөрт эсвэл хязгаарлагдмал орчинд ажиллах, хүнд машин механизм ашиглах, аюултай материал ашиглах зэрэг аюултай ажил гүйцэтгэх
    - Хүүхдийн хөдөлмөр эсвэл албадан хөдөлмөр гарч болзошгүй эрсдэл.
    - Цагаач эсвэл улирлын чанартай ажилчид байх магадлалтай эсэх.
    - Ажилчдын шилжилт хөдөлгөөн эсвэл жендерт суурилсан хүчирхийллийн эрсдэл.
    - Осол, онцгой байдал гарах магадлал.
    - Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагын талаар ерөнхий ойлголт, хэрэгжилт

- Үндэсний хөдөлмөрийн тухай хууль тогтоомжийн тойм: Нөхцөл ба болзол
  Энэхүү хэсэгт Монгол Улсын хөдөлмөрийн хууль тогтоомжийн гол заалтуудыг, ялангуяа хөдөлмөрийн нөхцөл, болзлын талаар танилцуулна. Үүнд үндсэн цалин, нэмэгдэл, хангамж, нийгмийн даатгал, татвар, бусад хууль ёсны суутгалууд, жирэмсний амралт, амралтын эрх, өвчний чөлөө болон бусад халамж багтана. Мөн ажлын хоногийн болон долоо хоногийн дээд хязгаар, илүү цагийн зохицуулалт, гэрээ байгуулах, цуцлах нөхцөл, ажилгүйдлийн тэтгэмж зэрэг асуудлуудыг хамарч, БОНС2-ын 11 дүгээр зүйлд тусгагдсан цалин хөлс, суутгал болон тэтгэмжийн талаар мэдээлэл өгнө.

- Үндэсний Хөдөлмөрийн Хууль Тогтоомжийн Тойм: Хөдөлмөрийн Аюулгүй Байдал ба Эрүүл Ахуй (ХАБЭА)

  Энэ хэсэгт Монгол Улсын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх үндсэн хууль тогтоомжийг танилцуулна. Үүнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартад нийцсэн ажлын байрыг бүрдүүлэх шаардлага, ажилчдад зориулсан аюулгүй ажиллагааны сургалт ба зааварчилгаа, ажлын байрны осол, мэргэжлээс шалтгаалсан өвчлөлийн бүртгэл, мэдээлэх журам, хувийн хамгаалалтын хэрэгслийг хангах, ашиглах журам, хөдөлмөрийн байцаагчийн хяналт шалгалт, зөрчлийн хариуцлага зэрэг асуудлуудыг хамруулна. Энэ бүхэн нь БОНС2-ын 24-30 дугаар зүйлд заасан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцэж буйг тодорхойлох зорилготой.

- Хариуцлагатай ажилтнууд

  Төслийн ажиллах хүчийг дараах чиглэлээр хариуцан ажиллах албан тушаалтнуудыг уг хэсэгт тодорхойлно.
    - төслийн ажилчдын оролцоо, менежмент
    - гүйцэтгэгч/туслан гүйцэтгэгчдийн оролцоо, удирдлага
    - хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (ХАБЭА)
    - ажилчдын сургалт
    - ажилчдын гомдлыг шийдвэрлэх

- Бодлого ба журам
- Ажиллах нас
- Ажиллах нөхцөл, болзол
- Гомдлын механизм
- Гүйцэтгэгчийн удирдлага
- Орон нутгийн ажилчид
- Үндсэн ханган нийлүүлэгчдийн ажилтнууд

ХАВСРАЛТ 6: БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮЛГЭРЧИЛСЭН ДҮРМИЙН ЖИШИГ ЗАГВАР

БОНҮАҮД-д барилгын үе шат болон үйл ажиллагааны үе шатад байгаль орчны менежментийг хэрэгжүүлэхтэй холбоотой арга хэмжээнүүдийг тусгасан байдаг. Энэхүү төслийн хувьд БОНҮАҮД нь дуу чимээ, тоосжилт, хог хаягдал, усны бохирдол гэх мэт ерөнхий сөрөг нөлөөллүүдийг хамарч, байгаль орчны хамгаалалтын шаардлагыг хангахад дэмжлэг үзүүлнэ. Түүнчлэн БОНҮАҮД-д туслан гүйцэтгэгч болон төслийн ажилчдын мөрдөх стандартчилагдсан зааварчилгааг өгснөөр төслийн эрсдэлүүдийг бууруулдаг.

БОНС-тэй нийцүүлэх:

- БОНС3 (Байгалийн нөөцийн зохистой ашиглалт, хүрээлэн буй орчны бохирдлын урьдчилан сэргийлэлт ба менежмент)-д төслийн үйл ажиллагаатай холбоотой хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулах, нөөцийн үр ашигтай байдлыг сайжруулах асуудлыг тодотгосон байдаг ба БОНҮАҮД-г ашиглах нь эдгээр асуудлуудыг шийдвэрлэхэд дөхөм болдог.

Жишиг загвар:

- Агаарын бохирдол болон дуу чимээний бохирдлын хяналт (тоос дарах, дуу чимээний бохирдол багасгах аргууд).
- Хог хаягдлын менежментийн протокол (хадгалах, устгах, дахин боловсруулах).
- Хөрсний элэгдлээс урьдчилан сэргийлэх, хурдасжилттай тэмцэх.
- Химийн хорт болон аюултай бодисын алдагдлаас урьдчилан сэргийлэх болон хариу арга хэмжээ авах журам.
- Тайлагнал ба нийцлийн механизм

ХАВСРАЛТ 7: ТҮР ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИШИГ ЗАГВАР

Төслийн үйл ажиллагаа хот суурин газрын нөхцөлд явагдах учир ТЗХМТ нь барилгын ажлын явцад тээврийн хэрэгсэл болон явган зорчигчдын хөдөлгөөнд учруулах саатал, хүндрэлийг хамгийн бага түвшинд байлгахад чиглэнэ. Уг төлөвлөгөө нь олон нийтийн аюулгүй байдлыг хангах, нийгмийн нэн чухал, шаардлагатай үйлчилгээний хүртээмжийг хадгалах, барилгын үйл ажиллагааны бүсэд ослын эрсдэлийг бууруулахад анхаардаг. Цаашилбал, үерийн суваг, үерийн хамгаалалтын далан/усан сан барих нь барилгын ажлын явцад ойр хавийн оршин суугчдын гэрт нэвтрэх замыг түр хугацаанд хаах магадлалтай гэж үзэж байна. Тиймээс, оршин суугчдыг түр замаар хангах нь чухал бөгөөд үүнийг Дэлхийн Банкны ESS4-ийн дагуу зохион байгуулах шаардлагатай.

БОНС4-ийн нийцэл:

- БОНС 4 (Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал)-ийн хүрээнд орон нутгийн иргэд, олон нийтийг барилгын ажилтай холбоотой эрсдэлээс хамгаалах асуудлыг чухалчилдаг ба ТЗХМТ нь замын хөдөлгөөнтэй холбоотой осол, аюулыг бууруулах замаар энэхүү стандарттай нийцдэг.

Жишиг загвар:

- ТЗХМТ-ний үндсэн зарчмууд
- ТЗХМТ-ний шаталсан бүтэц
- Барилгын явцад тээврийн урсгал болон нэвтрэх боломжийг хангах байршлын онцлогт тохирсон зохицуулалт
- Нөлөөлөлд өртөж болзошгүй иргэдийн санал, зөвлөмжид үндэслэсэн хяналт ба зохицуулалт.

ХЯНАСАН:

УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ ХОТЫН ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЦИЙН ГАЗРЫН ДАРГА, ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР Л.АЛТАНГЭРЭЛ

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗРЫН ХОТ БАЙГУУЛАЛТЫН ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЦИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ц. ЛХАМСҮРЭН

УЛААНБААТАР ХОТЫН УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР ОНӨААТҮГ-ЫН ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР Ж.ДАГВАСҮРЭН

ГЕОДЕЗИ УСНЫ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ГАЗАР ОНӨААТҮГ-ЫН ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР С.БАТСАЙХАН

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ДЭД БҮТЭЦ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХЭЛТЭС, УС ХАНГАМЖ АРИУТГАХ ТАТУУРГА, ИНЖЕНЕРИЙН БЭЛТГЭЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Д. ОЮУНЖАРГАЛ

УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ ХОТЫН ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЦИЙН ГАЗРЫН УСНЫ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Э.ТУНГАЛАГТАМИР

НИЙСЛЭЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН ХЭЛТСИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Э.ЖАРГАЛСАЙХАН

БОЛОВСРУУЛСАН:

ДЭЛХИЙН БАНКНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЗӨВЛӨХ

Э.АНАР-ЭРДЭНЭ